



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



ГЭМТ ХЭРЭГ - 2016





ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХИЙН СТАТИСТИК-2016

**УЛААНБААТАР
2017**

Санал, хүсэлт байвал доорхи хаягаар холбоо барина уу.

Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын III байр

Бага тойруу -44, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар -11, Монгол улс

Утас : (976-51)-263966

Факс : (976-11)-324518

Web хуудас : www.nso.mn, www.1212.mn

E-Mail : international@nso.mn; nso_hansg@nso.mn

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, 2017 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ЭХ ҮҮСВЭР, НӨХЦӨЛ, БАЙДАЛ	1
1.1 Гэмт хэргийн тухай ойлголт, тодорхойлолт	4
1.2 Гэмт хэргийн мэдээллийн үүсэл, эх үүсвэр	7
1.3 Гэмт хэргийн нөхцөл, байдал	8
БҮЛЭГ 2. ЦАГДААГИЙН СТАТИСТИК	
2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн илрүүлэлт	9
2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн төрлөөр	14
2.3 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	32
2.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаа, газар	35
2.5 Гэмт хэрэг үйлдэгчид	40
2.6 Гэмт хэргийн улмаас хохирсон иргэн	44
2.7 Гэр бүлийн хүчирхийлэл бол орчин цагийн боолчлол	48
2.8 Гэмт хэргийн улмаас хохирсон байгууллага	52
2.9 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэд	53
2.10 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт	57
2.11 Эрүүлжүүлэгдсэн, баривчлагдсан иргэд	60
БҮЛЭГ 3. ШҮҮХИЙН СТАТИСТИК	
3.1 Анхан шатны шүүхийн эрүүгийн хэрэг	63
3.2 Анхан шатны шүүхийн иргэний хэрэг	69
3.3 Анхан шатны шүүхийн захиргааны хэрэг	73
3.4 Давж заалдах шатны шүүхийн хэрэг	75
3.5 Хяналтын шатны шүүхийн хэрэг	77
БҮЛЭГ 4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХИЙН СТАТИСТИК	78
БҮЛЭГ 5. УЛС ОРНУУДЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС	80
БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ	83
БҮЛЭГ 7. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	88

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, 2016 оны байдлаар

- ⚖ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 7 нь нийслэлд
 - 3 нь аймаг, орон нутагт
 - 2 нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг
 - 1 нь эмэгтэйчүүд оролцсон хэрэг
- ⚖ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 5 нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
 - 3 нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байна.
- ⚖ Өмчлөх эрхийн эсрэг 10 гэмт хэрэг тутмын
 - 7 нь бусдын эд хөрөнгийг хулгайлах
 - 6 нь хувийн өмчийг хулгайлах
 - 2 нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах
- ⚖ Халаасны хулгайн хэргийн 99.0 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.
- ⚖ Нийслэлд бүртгэгдсэн халаасны хулгайн 10 хэрэг тутмын
 - 3 нь Сүхбаатар дүүрэгт
 - 3 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт
- ⚖ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг 10 хэрэг тутмаас
 - 10 нь бусдын бие махбодид гэмтэл учруулах
 - 6 нь нийслэлд
- ⚖ Нийслэлд бүртгэгдсэн хүний амь бие эрүүл мэндийн эсрэг 10 хэрэг тутмын
 - 2 нь Сонгинохайрхан дүүрэгт
 - 2 нь Баянзүрх дүүрэгт
 - 2 нь Баянгол дүүрэгт
- ⚖ Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг 10 хэрэг тутмын
 - 8 нь хүчингийн хэрэг байна.
- ⚖ Гэмт хэргийн илрүүлэлт
 - хамгийн багатай аймаг, дүүрэг- Дорноговь аймаг (57.9 %), Баянзүрх дүүрэг (54.7 %)
 - хамгийн өндөртэй аймаг, дүүрэг- Баян-Өлгий аймаг (88.7%), Налайх дүүрэг (72.0 %) байна.
- ⚖ Бүртгэгдсэн 10 гэмт хэрэг тутмын
 - 8 нь ажлын цагаар
 - 2 нь амралтын цагаар
 - 3 нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байна.
- ⚖ Гудамж, талбайд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
 - 4 нь гэр хорооллын гудамжинд үйлдэгджээ.
- ⚖ Гэр орон сууцанд үйлдэгдсэн 10 хэрэг тутмын
 - 4 нь гэрт
 - 2 нь орон сууцны байранд
 - 3 нь хувийн байшинд
- ⚖ Хэрэгт холбогдсон 10 хүн тутмын
 - 5 нь ажилгүй иргэд
 - 4 нь 18-29 насны залуучууд
 - 4 нь бүрэн дунд боловсролтой
 - 2 нь эмэгтэй

- 2 нь согтуугаар үйлдсэн
- Гэмт хэрэгт холбогдсон 100 сэжигтэн холбогдогч тутмын 7 нь өмнө нь ял эдэлж байсан хүн байна.


 Гэмт хэргийн улмаас Монгол Улсын 10 000 хүн тутмаас

2015 онд


- 93 иргэн хохирсны 37 нь эмэгтэй, 5 нь 18 хүртэлх насны хүүхэд

2016 онд


- 89 иргэн хохирсны 41 нь эмэгтэй, 5 нь 18 хүртэлх насны хүүхэд

 Гэмт хэргийн улмаас хохирсон 10 хүн тутмын


- 5 нь 18-34 насны залуучууд
- 6 нь эрэгтэйчүүд
- 3 ажилгүй иргэд байна.

 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын


- 8 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн
- 6 нь тухайн хүчирхийлэгчийн эхнэр байна.

 Гэмт хэргийн улмаас хохирсон 100 хүн тутмын


- 3 нь нас барсан
- 41 нь гэмтсэн хүн байна.

 Гэмт хэргийн улмаас нас барсан 10 хүн тутмын

- 5 нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас
- 3 нь эмэгтэй хүн

 Гэмт хэргийн улмаас гэмтсэн 10 хүн тутмын

- 7 нь Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас
- 1 нь Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг

 Гэмтсэн 100 хүн тутмын

- 7 нь хүнд гэмтэл авсан
- 14 нь хүндэвтэр гэмтэл авсан байна.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, оноор

Үзүүлэлтүүд	нэгж	2015 он	2016 он	Өөрчлөлт
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	27 757	27 167	↓
хөнгөн	тоо	13 487	13 519	↑
хүндэвтэр	тоо	12 127	11 767	↓
хүнд	тоо	1 628	1 393	↓
онц хүнд	тоо	515	488	↓
Үндэсний аюулгүй байдлын эсрэг	тоо	10	36	↑
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	тоо	8 468	8 691	↑
Хүний эрх, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг	тоо	57	44	↓
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг	тоо	383	384	↑
Иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг	тоо	141	116	↓
Өмчлөх эрхийн эсрэг	тоо	13 445	13 336	↓
Аж ахуйн эсрэг	тоо	520	227	↓
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	тоо	1 630	1 479	↓
Хүн амын эрүүл мэндийн эсрэг	тоо	341	416	↑
Байгаль хамгаалах журмын эсрэг	тоо	228	165	↓
ТХХАБАЖ-ын эсрэг	тоо	2 010	1 783	↓
Шүүн таслах ажиллагааны эсрэг	тоо	106	91	↓
Албан тушаалын гэмт хэрэг	тоо	128	111	↓
Цэргийн албаны эсрэг	тоо	12	10	↓
Хохирогч иргэн	тоо	27 948	27 689	↓
Нас барсан	тоо	847	880	↑
Гэмтсэн	тоо	11 287	11 257	↓
Хохирогч байгууллага	тоо	113	84	↓
Учирсан хохирол	тэрбум.төг	144.3	162.9	↑
Нөхөн төлүүлэлт	тэрбум.төг	49.0	44.0	↓
Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг	тоо	6 756	5 762	↓
Шүүхээр ял шийтгүүлсэн хүн	тоо	7 696	6 566	↓
Шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан	тоо	1 487	2 220	↑
Ажлаас буруу шилжүүлсэн	тоо	18	59	↑
Ажлаас үндэслэлгүй халагдсан	тоо	910	1 213	↑
Цалин хөлсний маргаан	тоо	415	653	↑
Шүүхийн шийдвэрээр нөхөн төлүүлсэн				
Эрүүгийн хэрэг	сая төг	17 702.9	10 611.6	↓
Иргэний хэрэг	сая төг	123 596.4	137 193.3	↑
Захиргааны хэрэг	сая төг	684.0	1 322.6	↑
Бусад хэргийн шийдвэртэй	сая төг	26 247.5	543.3	↓
Авлигын хэргийн шийдвэрлэлт				
Эрүү үүсгэсэн хэрэг	тоо	92	83	↓
Эрүүгийн хэргийн сэжигтэн	тоо	174	164	↓
Учирсан хохирол	сая төг	50 290.4	37 727.8	↓
Нөхөн төлүүлсэн	сая төг	2 945.3	2 808.9	↓

1. УДИРТГАЛ

1.1 ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг **гэмт хэрэг** гэж тодорхойлсон байна. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны суурин хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг **яллагдагч** гэнэ.

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж байгаа болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй этгээдийг **ял шийтгэгдсэн хүн** гэнэ.

1.2 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Ойлголт	Тодорхойлолт
1	Гэмт хэрэг	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Хүнийг санаатай алах, эх нь нярай хүүхдээ алах, санаа сэтгэл нь хүчтэй цочирдон давчдсан үед бусдыг санаатай алах, бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх, бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах, тарчлаах зүйл ангиудыг хамааруулна.
3	Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг	Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс бусдын биед санаатай буюу болгоомжгүй байдлаар хүнд, хүндэвтэр, хөнгөн хэлбэрийн гэмтэл учруулсныг хамааруулна.
4	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Танхайрах, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис буюу хордуулах цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, уулгалан довтлох, зандалчлах, терроризм, аюулгүй ажиллагааны журам зөрчих, нийтийн эмх замбараагүй байдал буй болгох зүйл ангиудыг хамааруулна.
5	Өмчлөх эрхийн эсрэг	Бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгөнд болгоомжгүйгээр хохирол учруулах, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, өмчлөгчийн эрхийг зөрчих зэрэг зүйл ангиудыг хамааруулна.
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих, зам тээврийн ослын үед үүргээ биелүүлэхгүй байх, зугатаах, согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах, жолоогоо бусдад шилжүүлэх, төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих, агаарын хөлөг авч зугтаах, Олон улсын нислэгийн журам зөрчих, тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх зэрэг зүйл ангиудыг хамааруулна.
7	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт хүн хулгайлах, хүнийг хууль бусаар хорих, доромжлох, гүтгэх, хүн барьцаалах, хүн худалдаалах зэрэг зүйл ангиудыг хамааруулна.
8	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, хүүхэд хаях, төөрүүлэх, асран хамгаалах үүргээ урвуулах, сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, эцэг, эх, эхнэр, нөхөр төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх, 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, садар самууныг сурталчлах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, хүчиндэх, эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх, эмнэлгийн бус нөхцөлд үр хөндөх, булш сүйтгэх зэрэг гэмт үйлдлүүдийг хамааруулна.

9	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх, сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх, сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих, иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгих, иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих, хувь хүний нууцыг задруулах, иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих, сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, шинэ бүтээл бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих, хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих, шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгих, шашны харгис үзэл номлол сурталчлах, тараах зэрэг гэмт үйлдлүүдийг багтаана.
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	Агаар бохирдуулах, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих, газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих, байгаль орчныг бохирдуулах, химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих, газрын хөрс, усыг бохирдуулах, усны тухай хууль тогтоомж зөрчих, ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих, байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах, ойн тухай хууль тогтоомж зөрчих, байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих, ой, хээрийн түймэр тавих, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих зэрэг үйлдлүүдийг хамруулна.
11	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах, мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах, хууль бусаар эмчлэх, хууль бусаар эм, эмнэлэгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх, тахал болон гоц халдварт бусад өвчинтэй тэмцэх журам зөрчих, хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах зэрэг үйлдлүүд орно.
12	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	Банк, хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих, банкны үйл ажиллагаанд албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж оролцох, үнэт цаас, даатгал, аудит, эрдэнэсийн сангийн тухай хууль, тогтоомж зөрчих, хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах, санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулах, санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах, татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах, дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж арилжаанд оролцох, үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах, хэрэглэгчийг хуурч, мэхлэх, төөрөгдүүлэх, хууль бусаар шан харамж авах, гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, согтууруулах ундааг хориглосон зүйлээр бэлтгэх, чанар муутай барилга бариулах, ашиглалтанд оруулах, эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх, мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах зэрэг үйлдлүүд багтана.

1.3 Гэмт хэргийн статистикийн мэдээллийн үүсэл, эх үүсвэр

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар 1950 онд байгуулагдсанаар гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын түвшинд цуглуулж эхэлсэн байна.

1933 онд батлагдсан “Цагдаагийн байгууллагын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно, мөн хуулийн 28 дугаар зүйлд Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл, технологийн төвийн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй.

Манай улсад гэмт хэргийн мэдээлэл 1980-аад оноос улам өргөжин мэдээлэл технологийн дэвшилтэт арга технологийг ашиглах болж, улмаар гэмт хэргийн салбарын мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн байна.

1993 онд батлагдсан “Шүүхийн тухай” хуулийн 55 дугаар зүйлд “ Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик тоон мэдээлэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасны дагуу Шүүхийн судалгаа, мэдээллийн төв байгуулагдан ажилласнаар Монгол улсад шүүхийн статистикийн үндэс суурь тавигдсан түүхтэй.

Олон улсын түвшинд гэмт хэргийн статистик нь хоёр эх үүсвэрээс бүрддэг байна. Үүнд:

1. Гэмт хэрэг, шүүхийн албан болон захиргааны статистикийн мэдээлэл
2. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн судалгаа

Манай орны хувьд гэмт хэргийн статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь одоогоор Цагдаагийн Ерөнхий Газрын сар бүрийн мэдээ, Улсын Дээд Шүүхийн хагас, бүтэн жилийн тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хагас, бүтэн жилийн мэдээ, Авлигатай тэмцэх газрын хагас, бүтэн жилийн мэдээ байна. Эдгээр мэдээллийн эх үүсвэрт үндэслэж гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, холбогдогч, хохирогч, учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, ял шийтгэгдсэн хүний тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан, шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлөгдсөн хохирлын хэмжээ, хүүхдийн тэтгэлэгийн нөхөн төлбөр, авлигын хэргийн шийдвэрлэлт, хорихоос өөр төрлийн ял зэрэг үзүүлэлтийг сар, улирал, жилийн бюллетень, танилцуулга, эмхэтгэлд тусган нийтэд хүргэж байна.



1.4 ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Гэмт хэргийн гаралт, түүний хандлага, бүтэц, тархалт, гэмт хэрэг үйлдэгчдийн байдалд нөлөөлдөг үндсэн 3 хүчин зүйл байдаг:

- Эдийн засгийн хүчин зүйл
- Нийгмийн орчны хүчин зүйл
- Гэр бүлийн хүчин зүйл

Эдийн засгийн хүчин зүйлд санхүүгийн нөөцийн хомс байдал, ядуурал, боловсрол олж авах болон ажил эрхлэх боломж муу байх, орон сууцны нөхцөл муу байх, байгууллагын хариуцлага хангалтгүй байх зэрэг олон хүчин зүйлс багтдаг.

Нийгмийн орчны хүчин зүйлд гэр бүлд үзүүлэх дэмжлэг бага байх, хүүхэд, хувь хүний төлөвшилд анхаарал бага тавих, иргэдийн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчин, нөхцөл муу байх зэрэг олон зүйлүүд багтдаг.

Гэр бүлийн хүчин зүйлд дараах зүйлүүд ордог. Үүнд:

- Эцэг, эхийн үл нийцэх байдал, хоорондын зөрчил
- Эцэг, эх гэмт хэрэг үйлдэх, хэрэгт холбогдох
- Бие, биеэ үл хүндэтгэх, хариуцлага хүлээхгүй байх
- Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийлэх, хайхрахгүй байх
- Гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрүүд

ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТАНД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД




БҮЛЭГ 2. ЦАГДААГИЙН СТАТИСТИК

2.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ИЛРҮҮЛЭЛТ


Гэмт хэрэг бол нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засгийн чадавхи доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэхэд гэмт хэрэг ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой.

Улсын хэмжээгээр 2016 онд 27.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2000 оноос 3704 (15.8%), 2005 оноос 9756 (56.0%), 2010 оноос 7342(37.0%)-оор өсч, харин 2015 оноос 590 (2.1%)-ээр буурсан байна (Зураг 2.1.1).

Зураг 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, 2000-2016 он




Зураг 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 25 жилд



Сүүлийн 25 жилийн хугацаанд хамгийн бага гэмт хэрэг бүртгэгдсэн жил 1990 он, хамгийн олон хэрэг бүртгэгдсэн жил 2015 он байна (Зураг 2.1.2).

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 13.5 хувь нь Төвийн бүсэд, 10.7 хувь нь Хангайн бүсэд, 5.3 хувь нь Баруун бүсэд, 4.5 хувь нь Зүүн бүсэд, 65.9 хувь нь нийслэлд, 0.1 хувь нь хилийн чанадад бүртгэгджээ.

Зураг 2.1.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүс, нийслэлээр, хувиар, 2011-2016 он




Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.3 хувийг хүндэвтэр, 49.8 хувийг хөнгөн, 5.1 хувийг хүнд, 1.8 хувийг онц хүнд хэрэг эзэлж, өмнөх оноос хөнгөн хэргийн эзлэх хувь 1.2 пунктээр нэмэгдэж, харин хүнд хэргийнх 0.8 пункт, хүндэвтэр хэргийнх 0.4 пунктээр буурч, онц хүнд хэргийнх өмнөх оны түвшинд байна (Хүснэгт 2.1.1).

Хүснэгт 2.1.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангиллаар, 2008-2016 он

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	20 704	20 373	19 825	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167
Гэмт хэрэг, ангиллаар									
Хөнгөн	7 854	7 857	8 151	7 977	9 637	11 648	13 057	13 487	13 519
Хүндэвтэр	10 165	10 006	9 219	8 889	10 041	11 514	11 951	12 127	11 767
Хүнд	2 352	2 126	2 014	1 823	1 914	1 766	1 781	1 628	1 393
Онц хүнд	333	384	441	508	497	434	529	515	488

Бүртгэгдсэн гэмт хэргийг тухайн сараар авч үзэхэд, 2014 оны 10 дугаар сард 3006 хэрэг бүртгэгдсэн нь хамгийн их, 2013, 2014 оны хоёрдугаар сард 1978 бүртгэгдсэн нь хамгийн бага байна. Харин жил бүрийн 2-р сард гэмт хэрэг буурч, 3-р сард хэрэг өссөн байна (Зураг 2.1.4).

Зураг 2.1.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар, 2013-2016 он



Гэмт хэргийн илрүүлэлт гэдэг нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргээс гэмт хэрэг үйлдсэн эзнийг нь тогтоож ял сонгосон хэргийн хувийн жингээр тооцогддог чанарын үзүүлэлт юм.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 54.5 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа ба 2016 онд өмнөх оноос 4.3 пунктээр өссөн байна (Хүснэгт 2.1.2).

Хүснэгт 2.1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, хэргийн илрүүлэлт, 2008-2016 он

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэгдсэн гэмт хэрэг	20 704	20 373	19 825	19 197	22 089	25 362	27 318	27 757	27 167
Бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг	6 692	7 086	6 445	6 504	8 140	10 910	12 585	13 922	14 796
Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдсон хэрэг	2 231	3 890	3 859	3 999	4 585	6 382	7 370	8 644	9 465
Илрүүлэлтийн хувь	33.3	54.9	59.9	61.5	56.3	58.5	58.6	62.1	64.0


Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 2016 онд Дорноговь аймагт хамгийн бага (57.9), харин Баян-Өлгий (88.7), Сүхбаатар (84.0), Сэлэнгэ (79.8) аймгуудад хамгийн өндөр байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дүнгээр 64.0 хувь, нийслэлд 61.5 хувь болж, улсын хэмжээнд өмнөх оноос 1.9 пункт, нийслэлд 2.6 пунктээр тус тус өссөн байна.

Зураг 2.1.5 Гэмт хэргийн илрүүлэлт, хувиар, 2016 он




Гэмт хэргийн илрүүлэлт 2016 онд өмнөх оноос нийслэлд 2.6 пунктээр өсөхөд Сонгинохайрхан(7.7), Сүхбаатар(3.0) дүүргүүдэд пунктээр өссөн нь голлон нөлөөлжээ. Гэмт хэргийн илрүүлэлт Багахангай(40.0 пункт) дүүрэгт өмнөх оноос хамгийн их буурсан байна.

Зураг 2.1.6 Гэмт хэргийн илрүүлэлт, дүүргээр, хувиар, 2011-2016 он



Улсын дунджаар 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2016 онд 137 гэмт хэрэг ногдож байгаа нь 2007 оноос 8 хэрэг буюу 6.2 хувиар өсч, 2000 оноос 39 хэрэг буюу 22.2 хувь, 2015 оноос 4 хэрэг буюу 2.8 хувиар буурсан байна.

**Зураг 2.1.7 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг,
2000-2016 он**




Сүүлийн 16 жилд 18 ба түүнээс дээш насны 10 000 хүнд ногдох гэмт хэрэг 2000 онд хамгийн их (176) байна. Улсын дунджаар 2016 онд 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд ногдох гэмт хэрэг 137 байгаа бөгөөд Говьсүмбэр (198), Дорноговь (160) аймгууд болон Улаанбаатар (198) хотод улсын дунджаас дээгүүр байна.

2.2 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТӨРЛӨӨР

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл 2016 онд нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 49.1 болж өмнөх оноос 0.7 пункт, Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 32.0 болж 1.5 пунктээр нэмэгдэж, харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 6.6 болж 0.6 пункт, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 5.4 болж 0.5 пункт, аж ахуйн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 1.1 пунктээр буурсан байна.

Зураг 2.2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он




Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2016 онд 8691 бүртгэгдсэн нь өмнөх оноос 227 буюу 2.6 хувиар өсчээ. Хүнийг санаатай алах гэмт хэрэг өмнөх оноос 0.4 пункт, бусдыг болгоомжгүй алах хэрэг 0.1 пункт, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 0.3 пунктээр буурч, харин бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 0.7 пунктээр өсчээ.

Хүснэгт 2.2.1 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он

Хэргийн төрөл	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 512	5 280	5 843	6 524	6 808	6 813	6 462	7 155	8 156	8 697	8 468	8 691
Хүнийг санаатай алах	310	311	300	213	223	230	262	231	204	211	204	174
Бусдыг болгоомжгүй алах	16	15	14	23	16	15	21	14	21	27	32	24
Бусдын биед гэмтэл учруулах	2 991	3 584	4 614	5 319	5 770	5 821	5 838	6 546	7 564	8 132	8 064	8 248
Бусдыг амиа хорлоход хүргэх	1 167	1 340	888	945	764	727	314	324	323	288	144	206
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	119	51	46	48	43	24	26
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	608	263	278	275	245	120	180
Бусад	28	30	27	24	35	20	27	40	44	39	24	39
Дүнд харьцуулсан хувь												
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хүнийг санаатай алах	6.9	5.9	5.1	3.3	3.3	3.4	4.1	3.2	2.5	2.4	2.4	2.0
Бусдыг болгоомжгүй алах	0.3	0.3	0.2	0.4	0.2	0.2	0.3	0.2	0.3	0.3	0.4	0.3
Бусдын биед гэмтэл учруулах	66.3	67.9	79.0	81.5	84.8	85.4	90.3	91.5	92.7	93.5	95.2	94.9
Бусдыг амиа хорлоход хүргэх	25.9	25.4	15.2	14.4	11.2	10.7	4.9	4.5	3.9	3.3	1.7	2.4
Амиа хорлосон хүн	-	-	-	-	-	16.4	16.2	14.2	14.9	14.9	16.7	0.3
Золгүй явдлаас нас барсан	-	-	-	-	-	83.6	83.8	85.8	85.1	85.1	83.3	2.1
Бусад	0.6	0.5	0.5	0.4	0.5	0.3	0.4	0.6	0.6	0.5	0.3	0.4

Зураг 2.2.2 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он



Бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 26.0 хувийг бүртгэгдэх үедээ сэжигтэн нь тогтоогдоогүй хэрэг эзэлж байгаа нь 2015 оныхоос 5.9 пунктээр нэмэгдсэн байна. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт 2016 онд улсын хэмжээнд 88.7 хувь байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр буурчээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 94.9 хувийг бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 0.3 пунктээр буурчээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 60.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул(249), Хөвсгөл(235), Сэлэнгэ(233), Төв (233), Орхон (218), Дорноговь (223) аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгуудынхаас их байна.


Зураг 2.2.3 Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг ба бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг, 2006-2016 он




Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 2.0 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна. Хүнийг санаатай алах хэргийн илрүүлэлт 2016 онд 98.8 хувь байгаа нь өмнөх оны түвшинд байна.

Сүүлийн 20 жилийн байдлаар хүнийг санаатай алах гэмт хэрэг 2013, 2015 онд (204) хамгийн бага, 2000 онд (367) хамгийн олон бүртгэгдсэн байна (Зураг 2.2.4).

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг сүүлийн 10 жилийн байдлаар 2014 онд хамгийн их (8132), 2006 онд хамгийн бага (3584) бүртгэгджээ (Зураг 2.2.3).

Зураг 2.2.4 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, 1995-2016 он

Хүнийг санаатай алах хэрэг 2016 онд Сэлэнгэ, Хөвсгөл, Дорноговь, Дархан-Уул, Завхан, Архангай, Баян-Өлгий, Увс, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод өмнөх оноос буурсан хэдий ч Булган, Орхон, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгуудад нэмэгдсэн байна.

Зураг 2.2.5 Хүнийг санаатай алах гэмт хэргийн гаралт ихтэй аймгууд, 2016 он

Зураг 2.2.6 Хүнийг санаатай алах гэмт хэрэг, сүүлийн 26 жилд

Хүнийг болгоомжгүйгээр алах гэмт хэрэг 2016 онд 24 бүртгэгдсэн нь өмнөх оноос 8 (25.0%) аар буурч, илрүүлэлт 100.0 хувь байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 52.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн гаралт Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдэд их байна. Амиа хорлосон хүн 2016 онд 26 болж өмнөх оноос 2 буюу 8.3 хувь, золгүй учралаар амь насаа алдсан хүн 180 болж, 60 буюу 50.0 хувиар өссөн байна.


Зураг 2.2.7 Амиа хорлосон болон золгүй явдлаар нас барсан хүн, 2010-2016 он**Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2016 онд 13336 бүртгэгдэж, өмнөх оноос 109 хэрэг буюу 0.8 хувиар буурахад энэ төрлийн гэмт хэргийн 68.0 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 104 (1.1%), мал хулгайлах гэмт хэрэг 375 (31.8%), халаасны хулгайн хэрэг 83 (13.4%), бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 63 (11.7%), бусдын эд хөрөнгийг булаах хэрэг 40 (18.5%), бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэрэг 11 (3.3%)- ээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2.2.2 Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он

Хэргийн төрөл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	8 847	10 865	9 489	8 853	7 944	7 232	9 023	11 118	12 551	13 445	13 336
Хулгай	6 657	7 927	6 609	6 376	5 777	5 276	6 266	7 884	8 424	9 169	9 065
Булаалт	418	703	354	167	143	137	179	227	245	216	176
Дээрэм	455	656	818	754	520	536	552	620	686	537	474
Залилан	669	816	866	801	764	688	1 098	1 231	1 843	2 067	2 165
Завших, үрэгдүүлэх	341	357	331	348	337	202	269	326	297	333	322


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдхүүнд ордог хулгайн хэрэг 2016 онд өмнөх оноос 0.2 пункт, булаах хэрэг 0.3 пункт, дээрэмдэх хэрэг 0.4 пункт, завших үрэгдүүлэх хэрэг 0.1 пунктээр буурсан хэдий ч залилангийн хэрэг 0.9 пунктээр өссөн байна (Хүснэгт 2.2.2.).

Зураг 2.2.7 Хулгайн хэргийн бүтэц, төрлөөр, 2015-2016 он

Иргэдийн өмчийг хулгайлах хэрэг 1991 оноос 2000 он хүртэлх хугацаанд өссөн бөгөөд 2004 оноос хойш буурч байгаад сүүлийн жилүүдэд эргээд өсөх хандлагатай байна.


Бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 1990 оноос 1993 онд эрс нэмэгдэж 9242-д хүрсэн нь сүүлийн 25 жилийн хугацаанд хамгийн их хулгай гарсан жил байжээ.

Зураг 2.2.8 Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, 2006-2016 он



Малын хулгайн 805 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 3.0 хувийг эзэлж, өмнөх оноос 1.3 пунктээр буурчээ.

Зураг 2.2.9 Малын хулгайн гэмт хэрэг, 2006-2016 он




2016 онд малын хулгайн хэрэг Архангай(84), Төв(76), Хөвсгөл(64) аймгуудад хамгийн их гарсан бол Өмнөговь(6), Говь-Алтай(9), Говьсүмбэр(9) аймгуудад хамгийн бага бүртгэгдсэн байна.

Зураг 2.2.10 Малын хулгайн гаралт ихтэй аймгууд, 2016 он



Тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг 404 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 1.5 хувийг эзэлж, өмнөх оноос 37 хэрэг буюу 10.1 хувиар өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 70.1 хувь болж, өмнөх оноос 4.3 пунктээр өссөн байна.

Зураг 2.2.11 Авто тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг, 2006-2016 он



Авто тээврийн хэрэгслийн хулгай 2016 онд 2006 оноос 4.3 дахин, 2010 оноос 2.8 дахин, 2015 оноос 10.1 хувиар нэмэгдсэн байна.

Халаасны хулгай 2016 онд 538 бүртгэгдсэн нь өмнөх оноос 83 хэрэг буюу 13.4 хувиар буурсан байна. Халаасны хулгайн 99.0 хувь нь нийслэлд бүртгэгдсэн бөгөөд Сүхбаатар дүүрэгт 170 хэрэг буюу 32.0 хувь, Баянзүрх дүүрэгт 148 буюу 27.8 хувь, Баянгол дүүрэгт 123 буюу 23.1 хувь нь бүртгэгджээ. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг 2016 онд 2165 бүртгэгдэж, өмнөх оноос 98 хэрэг буюу 4.7 хувиар нэмэгдэж, харин завших, үрэгдүүлэх хэрэг 322 бүртгэгдсэн нь өмнөх оноос 11 хэрэг буюу 3.3 хувиар, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 176 болж, өмнөх оноос 40 хэрэг буюу 18.5 хувиар буурчээ (Зураг 2.2.12).


Зураг 2.2.12 Бусдын эд хөрөнгийг булаах, залилан мэхэлж авах, завших, үрэгдүүлэх гэмт хэргийн гаралт, 2006-2016 он




Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 2016 онд 474 бүртгэгдсэн нь өмнөх оноос 63 хэрэг буюу 11.7 хувиар буурсан байна.


Дээрмийн хэрэг 2003 онд 825 бүртгэгдэж байсан нь сүүлийн 26 жилийн хугацаанд хамгийн өндөр үзүүлэлт байлаа.

Зураг 2.2.13 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг, сүүлийн 26 жилд




Зураг 2.2.14 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг, 1995-2016 он**Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг**

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2016 онд 1479 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 151 хэрэг буюу 9.3 хувиар буурчээ. Бүртгэгдсэн нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 60.5 хувь нь бүртгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй, 45.8 хувь нь ял сонгосон хэрэг байгаа ба энэ төрлийн хэргийн илрүүлэлт 75.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 4.1 пунктээр буурсан байна.

Зураг 2.2.15 Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2004-2016 он

Танхайн гэмт хэрэг 2016 онд 1449 бүртгэгдсэн ба 2015 оноос 133 хэрэг буюу 8.4 хувиар буурахад Архангай, Булган, Ховд, Увс, Баянхонгор, Дундговь, Дархан-Уул аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн тоо өмнөх оноос 52.2-90.9 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Зураг 2.2.16 Танхайрах гэмт хэрэг, 1995-2016 он


Танхайн гэмт хэрэг улсын дүнгээр буурсан хэдий ч 2016 онд Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь аймгуудад өмнөх оноос 47.1 хувиас 2 дахин өссөн байна. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Хэнтий(39), Төв(28), Дорноговь(25) аймгуудад хамгийн их гардаг байна.

Улсын хэмжээгээр бүртгэгдсэн нийт танхайн гэмт хэргийн 1204 буюу 83.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байгаа бөгөөд өмнөх оноос 49 буюу 3.9 хувиар буурсан байна. Улаанбаатар хотод гарсан танхайн гэмт хэргийн 292 буюу 24.3 хувь нь Баянзүрх, 265 буюу 22.0 хувь нь Баянгол, 207 буюу 17.2 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгджээ. Танхайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 75.6 хувь болж өмнөх оноос 4.1 пунктээр буурсан байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг


Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2016 онд 1783 болж, өмнөх оноос 227 хэрэг буюу 11.3 хувиар буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 87.8 хувь болж өмнөх оноос 1.9 пунктээр өссөн байна.

Зураг 2.2.17 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он




2016 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.6 хувийг ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.6 пунктээр буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргийн 51.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.0 пунктээр буурсан байна.

Зураг 2.2.18 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бүтэц, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он



Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 72.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг (ТХХАББАЖЗ), 25.1 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг эзэлж байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн дотор голлох хувийг эзэлж байгаа ТХХАББАЖ-ын эсрэг гэмт хэрэг 2015 оноос 3.0 пунктээр нэмэгдэж, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэрэг 3.0 пунктээр буурсан байна. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах хэрэг 2009-2012 онд тасралтгүй өссөн боловч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.

Зураг 2.2.19 ТХХАББАЖЗ-ын эсрэг гэмт хэрэг ба зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн гаралт, 2006-2016 он



Хүснэгт 2.2.3 Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн, 2007-2016 он


Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	1 597	1 551	1 358	1 191	922	901	949	1 078	847	880
Зам тээврийн ослын улмаас нас барсан хүн	344	313	317	325	363	369	424	503	429	399
Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн	7 759	9 096	8 593	7 486	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257
Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн	945	892	920	933	1 094	1 078	1 282	1 460	1 382	1 247

Гэмт хэргийн улмаас 2016 онд 880 хүн нас барсны 399 буюу 45.3 хувь нь зам тээврийн ослын улмаас нас барсан нь өмнөх оноос 5.3 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2016 онд 11257 хүн гэмтсэний 1247 буюу 11.1 хувь нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 399 хүний 89 буюу 22.3 хувь нь Улаанбаатар хотод гарсан хэргийн хохирогч байна. Баянзүрх(21), Сонгинохайрхан(16), Чингэлтэй(11) дүүргүүдэд зам тээврийн ослын улмаас хамгийн олон хүн амь насаа алджээ. Харин аймгуудаас Төв(47), Сэлэнгэ(33), Дорноговь(25), Хэнтий(23), Өвөрхангай(22) аймгуудад хамгийн олон хүн зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ.

Аж ахуйн эсрэг гэмт хэрэг

Аж ахуйн эсрэг гэмт хэрэг 2016 онд 227 бүртгэгдсэн нь өмнөх оноос 293 буюу 56.3 хувиар буурчээ. Аж ахуйн эсрэг гэмт хэрэг улсын хэмжээгээр буурахад Улаанбаатар хотод бүртгэгдсэн аж ахуйн эсрэг гэмт хэрэг 282 (61.3%) –оор буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.2.20 Аж ахуйн эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он




Улаанбаатар хотод аж ахуйн эсрэг гэмт хэрэг өмнөх оноос буурахад Чингэлтэй дүүрэгт 77.6 хувь, Баянзүрх дүүрэгт 62.7 хувь, Баянгол дүүрэгт 38.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Албан тушаалын гэмт хэрэг


Албан тушаалын гэмт хэрэг 2016 онд 111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 17 хэрэг буюу 13.3 хувиар буурсан байна. Сүүлийн 21 жилийн хугацаанд албан тушаалын гэмт хэргийн гаралт 2001 онд хамгийн олон (253) бүртгэгджээ.

Зураг 2.2.22 Албан тушаалын гэмт хэргийн гаралт, 1995-2016 он



Хээл хахууль авах гэмт хэрэг 47 бүртгэгдсэн нь 2015 оноос 15 хэрэг буюу 46.9 хувиар өсч, харин хээл хахууль өгөх гэмт хэрэг өмнөх оноос 3 -аар өсчээ.


Зураг 2.2.23 Хээл хахуулын гэмт хэрэг, 2006-2016 он



Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг

2016 онд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 44 буюу 0.2 хувийг Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 13-аар буурсан байна.

Зураг 2.2.24 Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он



2016 онд бүртгэгдсэн хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 61.5 хувь байгаа нь өмнөх оноос 2.7 пунктээр буурсан байна. 2016 онд бүртгэгдсэн хүний эрх, эрх чөлөө, нэр төрийн эсрэг 44 хэргийн 17 буюу 38.6 хувь нь доромжлох, 19 буюу 43.2 хувь нь гүтгэх, 3 буюу 6.8 хувь нь хүн барьцаалах, 3 буюу 6.8 хувь нь хүн худалдаалах гэмт хэрэг байна. 2016 онд бүртгэгдсэн 44 хэргийн 29 буюу 65.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг


Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 2016 онд 384 болж, өмнөх оноос 1 хэрэг буюу 0.3 хувиар өссөн байна. Энэ төрлийн хэргийн 75.5 хувийг эзэлж байгаа хүчингийн хэрэг 2016 онд 290 бүртгэгдэж, өмнөх оноос 11 хэрэг буюу 3.9 хувиар өсч, харин хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг 8 бүртгэгдэж, 7 буюу 46.7 хувиар, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг 20 бүртгэгдэж, 8 буюу 28.6 хувиар буурсан байна (Хүснэгт 2.2.4).

Хүснэгт 2.2.4 Хүүхэд, гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, төрлөөр, 2006-2016 он

	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Бүгд	352	343	384	426	375	410	434	405	425	397	383	384
Хүчиндэх	320	314	355	354	332	342	367	305	344	300	279	290
Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах	-	-	-	27	10	10	15	14	13	17	28	20

Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах 20 хэрэг бүртгэгдсэний 15 буюу 75.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Дүүргүүдээс биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах хэрэг Баянгол дүүрэг(8)-т хамгийн их гарсан байна.

Зураг 2.2.25 Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 2006-2016 он




Зураг 2.2.26 Хүчингийн гэмт хэрэг, 2006-2016 он



2.3 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДАЛ


2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 5520 буюу 20.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа нь өмнөх оноос 387 хэрэг буюу 6.6 хувиар буурав. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Дорнод аймгуудад буурсан нь голлон нөлөөлжээ. Бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 2016 онд 1635 болж, өмнөх оноос 639 хэрэг буюу 28.1 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 3516 болж өмнөх оноос 266 хэрэг буюу 7.0 хувь, хүүхэд оролцсон хэрэг 970 болж 174 хэрэг буюу 15.2 хувиар буурсан байна (Зураг 2.3.1).

Зураг 2.3.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, 2007-2016 он



Зураг 2.3.2 Сogтуугаар үйлдэгдсэн хэрэг хамгийн олон гарсан аймгууд,

2016 он




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өсөхөд Улаанбаатар хот (71), Дорноговь(28), Баянхонгор (15), Баян-Өлгий(10) аймгуудад өссөн нь голлон нөлөөлөв.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 1202 буюу 83.0 хувь нь хөнгөн, 165 буюу 11.4 хувь нь хүндэвтэр, 51 буюу 3.5 хувь нь хүнд, 31 буюу 2.1 хувь нь онц хүнд хэлбэрийн гэмт хэрэг байна. Хөнгөн хэлбэрийн гэр бүлийн хүчирхийлэл өмнөх оноос 5.2 пунктээр нэмэгдэж, харин хүндэвтэр хэрэг 2.2 пункт, онц хүнд хэрэг 0.7 пункт, хүнд хэлбэрийн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2.3 пунктээр буурчээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн 838 буюу 57.8 хувь нь Улаанбаатар хотод байна. Дүүргүүдээс Баянзүрх (253), Сонгинохайрхан (154), Баянгол (137) –д хамгийн их гэр бүлийн хүчирхийлэл бүртгэгджээ.

**Зураг 2.3.4 Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, гэмт хэргийн ангиллаар,
2015-2016 он**



**Зураг 2.3.3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг хамгийн
олон гарсан аймгууд, 2016 он**



Галт зэвсгээр үйлдэгдсэн, урьдчилан үгсэж, тохиролцон бүлгээр үйлдсэн, зохион байгуулалттай бүлгээр үйлдэгдсэн хэргүүд сүүлийн жилүүдэд буурсан хэдий ч мансуурсан үедээ үйлдэгдсэн хэрэг өмнөх оноос 20 буюу 44.4 хувиар өссөн байна.


Хүснэгт 2.3.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, 2008-2016 он

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	299	316	284	420	534	418	1 076	1 356	1 449
Урьдчилан үгсэж, тохиролцон бүлгээр үйлдэгдсэн	188	72	52	38	92	62	49	47	23
Галт зэвсгээр үйлдэгдсэн	71	49	27	39	41	42	39	38	33
Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн	11	7	3	2	16	11	3	-	-

2.4 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАРАГ, ЦАГ ХУГАЦАА, ГАЗАР


2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 75.3 хувь нь ажлын өдрүүдэд, 24.7 хувь нь амралтын өдрүүдэд үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 15.8 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 66.9 хувь нь нийслэлд, 33.1 хувь нь аймгуудад байна. Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр Даваа гарагт бусад гарагуудаас их хэрэг гардаг байна.

Зураг 2.4.1 Үйлдэгдсэн гэмт хэрэг гарагаар, дүнд эзлэх хувиар, 2011-2016 он




Зураг 2.4.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн гарагаар, дүнд эзлэх хувиар,

2016 он




2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зонхилох хэсэг нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байгаа бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 21.7 хувь нь 06-14 цагт, 28.6 хувь нь 14-19 цагт, 15.1 хувь нь 19-22 цагт, 34.6 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

Зураг 2.4.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн цагаар, 2016 он



Улаанбаатар хотод 2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 32.3 хувь нь шөнийн 22 цагаас өглөөний 06 цагийн хооронд, 30.0 хувь нь 14-19 цагийн хооронд, 23.2 хувь нь 06-14 цагийн хооронд, 14.5 хувь нь 19-22 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.9 хувь нь гэр, орон сууцанд, 20.2 хувь нь гудамж, талбайд үйлдэгджээ.

Зураг 2.4.4 Бүртгээгдсэн гэмт хэрэг, үйлдэгдсэн газраар, 2016 он

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэргийн 36.0 хувь нь гэрт, 21.8 хувь нь орон сууцны байранд, 30.2 хувь нь хувийн байшин, зуслангийн байшин, амины орон сууцанд, 7.7 хувь нь гарааж, амбаар, агуулах, орц, подвалд, 4.3 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна. Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн 37.8 хувь нь гэр хорооллын гудамжинд, 28.8 хувь нь орон сууцны хорооллын гудамжинд үйлдэгджээ.


Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэргийн 17.5 хувь нь дэлгүүрт, 25.2 хувь нь бааранд, 8.7 хувь нь худалдаа үйлчилгээний захад, 9.4 хувь нь зочид буудалд үйлдэгдсэн байна.

Нийтийн тээврийн газарт үйлдэгдсэн хэргийн 32.4 хувь нь том оврын автобусанд, 38.6 хувь нь таксинд үйлдэгдсэн байна.

Авто зам дээр гарсан гэмт хэрэг 2016 онд өмнөх оноос 279 буюу 14.2 хувиар буурахад Орхон(35), Булган(10), Баянхонгор(9), Өвөрхангай(8) аймгуудад өмнөх оноос буурсан нь голлон нөлөөлжээ.

Авто зам дээр гарсан нийт хэргийн 903 буюу 53.7 хувь нь Улаанбаатар хотод гарсан нь өмнөх оноос 2.8 пунктээр буурсан байна. Улаанбаатар хотод гарсан хэрэг өмнөх оноос буурахад Сонгинохайрхан(59), Чингэлтэй (48), Баянгол(51), Сүхбаатар(26) дүүрэгт буурсан нь голлон нөлөөлжээ.


Зураг 2.4.5 Авто зам дээр үйлдэгдсэн хэрэг, дүүргээр, 2015-2016 он



2016 онд авто зам дээр гарсан гэмт хэргийн 52.0 хувь нь хотын замд, 41.9 хувь нь орон нутгийн замд гарсан ба замын хучилтаар авч үзвэл, 76.7 хувь нь асфальтан зам дээр, замын гадаргуугийн хувьд 60.8 хувь нь хуурай гадаргууд, замын онцлогоор харвал 64.9 хувь нь тэгш, 27.5 хувь нь шулуун замд үйлдэгджээ.

Хотын замд гарсан 875 хэргийн 841 буюу 96.1 хувь нь Улаанбаатар хотод гарсан ба дүүргүүдээс Сонгинохайрхан(208), Баянзүрх(180), Баянгол(131), Сүхбаатар(119)-т хамгийн их хэрэг бүртгэгджээ.

Авто зам дээр үйлдэгдсэн 1682 хэргийн зонхилох хэсэг 1013 буюу 60.2 хувь нь үзэгдэх орчин чөлөөтэй зам дээр үйлдэгджээ. Үзэгдэх орчин чөлөөтэй зам дээр үйлдэгдсэн хэрэг өмнөх оноос 6.6 хувь, зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй зам дээр гарсан хэрэг 20.4 хувь, үзэгдэх орчин хангалтгүй зам дээр гарсан хэрэг 25.0 хувиар буурч, зорчих хэсэг гэрэлтүүлэггүй зам дээр гарсан хэрэг 16.2 хувиар буурсан байна.

Зураг 2.4.6 Авто зам дээр гарсан хэрэг, үзэгдэх орчноор, 2015-2016 он

Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэргийн 34.6 хувь нь хөдөө хээр, бэлчээрт үйлдэгдсэн нь өмнөх оноос 8.2 пунктээр буурсан байна.

Явган хүний гарц дээр гарсан 98 хэргийн 85 буюу 86.7 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Дүүргүүдээс Сүхбаатар(22), Баянгол(19), Баянзүрх(18)- д явган хүний гарцан дээр хамгийн их хэрэг гардаг байна.

Автозам дээр гарсан 1682 хэргийн 1166 буюу 69.3 хувь нь цаг агаарын таатай нөхцөлд, 82 буюу 4.9 хувь нь үүлэрхэг байхад, 31 буюу 1.8 хувь нь бороотойд, 51 буюу 3.0 хувь нь цастайд, 9 буюу 0.5 хувь нь манантайд, 13 буюу 0.8 хувь нь шуургатай байхад үйлдэгджээ.

Авто зам дээр үйлдэгдсэн хэргийг замын зорчих хэсгийн өргөнөөр нь авч үзвэл 7.0-9.0 м өргөнтэй зам дээр 480 буюу 28.5 хувь нь, 5.5-7 м өргөнтэй зам дээр 309 буюу 18.4 хувь нь, 9.0-12.0 м өргөнтэй зам дээр 214 буюу 12.7 хувь нь, 12.0-16.0 м өргөнтэй зам дээр 130 буюу 7.7 хувь нь зонхилон үйлдэгдсэн байна.


2.5 ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИД

“Эрүүгийн байцаан шийтгэх тухай” хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу дор дурдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан тохиолдолд сэжигтэн гэж үзнэ. Үүнд:

- Гэмт этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан.
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан.
- Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон.
- Уг этгээд хэргээ илчлэн ирсэн.

– Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа тохиолдлуудад сэжигтэнд тооцно. Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, холбогдогчдын тоо 2016 онд 23.8 мянган хүн болж, өмнөх оноос 1052 хүн буюу 4.2 хувиар буурсан байна. 2016 онд гэмт хэрэгт холбогдсон 23.8 мянган сэжигтэн, холбогдогчдын 6566 буюу 27.6 хувь нь ял шийтгүүлсэн нь өмнөх оноос 3.4 пунктээр буурсан байна (Зураг 2.5.1).

Зураг 2.5.1 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчдоос Шүүхээр ял шийтгүүлсэн хүн, 2006-2016 он




2016 онд гэмт хэргийн сэжигтэн, холбогдогчоор татагдсан 23.8 мянган хүний 3592 буюу 15.1 хувь нь эмэгтэйчүүд, 1165 буюу 4.9 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын 6.8 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь 2016 онд өмнөх оноос 0.9 пунктээр өсчээ.

Зураг 2.5.2 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчид, сүүлийн 10 жилийн байдлаар



Зураг 2.5.3 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, холбогдогчид, насны бүлгээр, хувиар, 2015-2016 он




2016 оны байдлаар гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчдын 60 хувь нь 18-34 насныхан байгаа бөгөөд 22.4 хувь нь 18-24 насных, 21.8 хувь нь 25-29 насных, 16.4 хувь нь 30-34 насныхан байна. Насны бүлгээр авч үзвэл 2016 онд 25-29 насныхан өмнөх оноос 0.4 пункт, 30-34 насныхан 0.3 пункт, 35-39 насныхан 0.3 пункт, 40-44 насныхан 0.4 пункт, 45-49 насныхан 0.4 пункт, 65-69 насныхан 0.1 пунктэ нэмэгдэж, харин 18 хүртэлх насныхан 0.8 пункт, 18-24 насныхан 0.9 пункт, 55-59 насныхан 0.1 пункт, 70-аас дээш насныхан 0.1 пунктээр буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 53.9 хувь нь ажилгүй иргэд, 5.5 хувь нь оюутан, сурагчид, 40.6 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүс байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогчдод ажилгүй иргэдийн эзлэх хувь 53.9 болж өмнөх оноос 3.5 пункт, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийнх 18.7 болж 0.6 пункт, төрийн бус байгууллагынх 2.0 хувь болж 0.2 пунктээр өсч, харин хувийн байгууллагад ажиллагчдынх 7.5 хувь болж 1.4 пункт, сурагчдынх 2.3 болж 0.3 пункт, оюутных 3.2 хувь болж 1.0 пункт, малчдынх 7.6 хувь болж 1.1 пункт, төрийн байгууллагынх 3.5 хувь болж 0.6 пунктээр буурсан байна (Зураг 2.5.4).

Зураг 2.5.4 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он




Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн холбогдогчдыг боловсролын түвшнээр нь авч үзвэл 44.5 хувийг бүрэн дунд боловсролтой, 20.6 хувийг суурь боловсролтой, 19.2 хувийг дээд боловсролтой, 8.5 хувийг бага боловсролтой хүмүүс эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос бүрэн дунд боловсролтой сэжигтэн, яллагдагчдын эзлэх хувь 1.4 пункт, тусгай мэргэжлийнх 0.2 пункт, дээд боловсролтойнх

0.1 пунктээр өсч, харин суурь боловсролтойнх 0.7 пункт, бага боловсролтойнх 0.3 пункт, боловсролгүй сэжигтэн холбогдогчийнх 0.6 пунктээр буурсан байна (Зураг 2.5.5).

Зураг 2.5.5 Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн холбогдогч, боловсролын

түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 23.1 хувь нь согтуугаар, 15.4 хувь нь бүлэглэж, 0.2 хувь нь урьдчилан үгсэн тохиролцож гэмт хэрэг үйлдсэн бол 61.3 хувь нь тодорхой бус шалтгааны улмаас гэмт хэрэг үйлджээ.

2.6 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭН, БАЙГУУЛЛАГА

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм. Нэг ч хүн

хохирохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн улс орны туршлага хаа ч байхгүй бөгөөд байх ч боломжгүй. Гэхдээ л иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг тасралтгүй үр ашигтай явуулах, нэгэнт хохирсон тохиолдолд түүний хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн тогтолцоо, үйл ажиллагааны зохистой нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдал аль ч улс орны хувьд нэн чухал байдаг байна.

Зураг 2.6.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг ба хохирогч иргэд, мянгаар, 2007-2016 он



Сүүлийн 10 жилд жил тутам дунджаар 25.7 мянган хэрэг Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, 25.2 мянган хүн гэмт хэргийн улмаас хохирчээ.

Гэмт хэргийн улмаас 2016 онд нийт 27.7 мянган иргэн, 84 байгууллага хохирсон нь 2015 оноос хохирогч иргэдийн тоо 259 хүнээр, хохирогч байгууллагын тоо 29-өөр буурчээ. Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо 11.3 мянга болж, өмнөх оноос 139-өөр өссөн байна. Хохирсон иргэдийн 59.0 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 1.0 пунктээр буурсан байна.


2016 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 13507 буюу 48.8 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 9126 буюу 33.0 хувь нь Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг, 1995 буюу 7.2 хувийг ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна. Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл өмнөх оноос хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1.4 пункт, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 1.1 пунктээр нэмэгдэж, харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 0.5 пункт, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 0.5 пункт, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 0.2 пункт, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 0.8 пунктээр буурсан байна.

Зураг 2.6.2 Хохирсон иргэд, 2007-2016 он




Хүснэгт 2.6.1 Хохирогч иргэд, гэмт хэргийн төрлөөр, 2007-2016 он

д/д	Гэмт хэргийн төрөл	Хохирогч иргэн									
		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	18	11	12	2	1	4	1	8	-	2
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5 930	6 599	6 948	6 828	6 500	7 167	8 285	8 951	8 825	9 126
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	27	24	27	38	23	36	52	62	63	48
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	382	411	378	395	413	383	408	385	369	377
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	57	90	62	62	70	116	126	147	137	120
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	9 723	9 495	8 490	7 928	7 070	8 838	11 012	12 625	13 509	13 507
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	14	41	31	51	31	67	95	220	217	143
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 843	1 703	1 520	1 766	1 904	1 753	1 927	1 799	1 727	1 559
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	198	251	277	300	234	216	273	245	266	318
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	23	56	58	102	159	284	262	256	237	161
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1 446	1 326	1 480	1 690	1 950	2 122	2 293	2 439	2 232	1 995
12	Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	3	-	-	-	11	8	8
13	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	123	157	173	154	163	234	203	219	248	234
14	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	42	50	50	42	57	52	59	81	76	70
15	Албан тушаалын гэмт хэрэг	37	27	25	11	12	8	10	19	27	12
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	68	15	14	9	5	14	9	8	7	9
17	Улсын дүн	19 931	20 256	19 545	19 381	18 592	21 294	25 015	27 475	27 948	27 689

Зураг 2.6.3 Хохирсон иргэд, хүйсээр, 2007-2016 он

**Зураг 2.6.4 Гэмт хэргийн улмаас хохирсон нийт иргэд, насны бүлгээр, хувиар
2015-2016 он**



25-29 насны хохирогч иргэдийн тоо өмнөх оноос 1.4 пункт, 30-34 насных 1.5 пункт, 40-44 насных 0.8 пункт, 50-54 насных 0.4 пунктээр нэмэгдэж, харин 18-24 насных 4.4 пункт, 18 хүртэлх насных 1.2 пунктээр буурсан байна. 18 хүртэлх насны хохирогчдын 15.5 хувь нь 7 хүртэлх насны, 28.0 хувь нь 8-13 насны, 56.5 хувь нь 14-17 насны хүүхдүүд байна.

2016 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 32.8 хувийг ажилгүй иргэд эзэлж байгаа нь 2015 оноос 2.6 пунктээр өсчээ. Хохирогч иргэдийн 7.6 хувь нь оюутан, сурагчид, 8.2 хувь нь төрийн албан хаагчид байна. Нийт хохирсон төрийн албан хаагчдын 136 буюу 6.0 хувь нь цагдаагийн албан хаагчид байгаа нь өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.

**Хүснэгт 2.6.2 Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд, гэмт хэргийн төрлөөр,
2007-2016 он**


д/д	Гэмт хэргийн төрөл	Хохирогч хүүхэд									
		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	1	-	-	-	-	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	290	363	350	343	375	391	398	453	419	375
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	2	1	-	1	2	6	2	6	3
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	158	170	184	202	196	202	182	189	194
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	3	1	2	5	11	5	4	3	6
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	330	246	204	187	210	269	373	471	413	345
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	-	4	-	-	7	2	1	-
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	86	75	75	95	125	115	102	101	100	63
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	41	67	85	67	50	41	85	62	63	82
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	1	-	-	1	-	-	2
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	195	162	158	181	208	244	246	297	282	268
12	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	1	-	-	1
13	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	1	1	2	2	-	-	2	1	1
14	Албан тушаалын гэмт хэрэг	-	1	-	-	-	-	-	-	-	-
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	1	-	-	-	-
16	Улсын дүн	1 151	1 080	1 045	1 066	1 178	1 270	1 426	1 576	1 477	1 340

Сүүлийн 10 жилийн байдлаар жилд дунджаар 1260 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хүүхдүүд ихэвчлэн Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирдог байна. Хохирогч өөрийн буруугаас болж хохирсон тохиолдол 256 гарсан нь 2015 оноос 61 буюу 19.2 хувиар буурчээ. Архидан согтуурсны улмаас 369 хүн хохирсон нь өмнөх оноос 54 буюу 17.1 хувиар өсчээ.


2.7 “ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛ ОРЧИН ЦАГИЙН БООЛЧЛОЛ”

Гэр бүлийн хүчирхийллийг орчин цагийн боолчлол хэмээн олон улсад үздэг байна. Орчин цагт “боолчлол” гэдэг ойлголт зөвхөн нийгмийн түвшинд яригдахаа больж, гэр бүлийн хүрээлэлд буй болжээ. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2016 онд 1449 бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 буюу 6.9 хувиар нэмэгдсэн байна. 2016 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нийт бүртгэгдсэн хэргийн 5.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2.7.1 Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, 2008-2016 он



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2016 онд 1357 хүн хохирсон нь 2015 оноос 50 буюу 3.8 хувиар нэмэгдэв. Эдгээр хүмүүсийн 1231 буюу 90.7 хувь нь эмэгтэйчүүд, 69 буюу 5.1 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.




Хүчирхийлэлд өртсөн иргэдийн 598 буюу 44.1 хувь нь ажилгүй иргэд, 128 буюу 9.4 хувь нь төрийн албан хаагч, 262 буюу 19.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 990 буюу 68.3 хувь нь 0-1 жил, 164 буюу 11.3 хувь нь 1-3 жил, 36 буюу 2.5 хувь нь 3-5 жил, 29 буюу 2.0 хувь нь 5-8 жил, 17 буюу 1.2 хувь нь 8-аас дээш жил хүчирхийлэлд автсан байна.


Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 926 буюу 63.9 хувь нь жилд 1-2 удаа, 110 буюу 7.6 хувь нь улиралд 1-2 удаа, 69 буюу 4.8 хувь нь сард 1-2 удаа, 29 буюу 2.0 хувь нь 14 хоног тутамд, 5 буюу 0.3 хувь нь 7 хоног тутам, 2 буюу 0.1 хувь нь 3 хоног тутам, 31 буюу 2.1 хувь нь байнгын хүчирхийлэлд автдаг байна. Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон иргэдийн 57.3 хувийг эхнэр нь, 15.8 хувийг хамтран амьдрагч нь, 2.9 хувийг төрсөн хүүхэд нь, 2.1 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

Зураг 2.7.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэд, бүсээр, дүнд эзлэх хувиар, 2008-2016 он



2016 оны байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 57.5 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна. Сэлэнгэ(50), Дархан-Уул(49), Орхон(47), Хөвсгөл(43), Төв(45) аймгууд болон Баянзүрх(234), Баянгол(127), Сонгинохайрхан(133) дүүргүүдийн иргэд гэр бүлийн хүчирхийлэлд хамгийн их автсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2016 онд 16 санаатай аллага бүртгэгдсэн нь нийт гэр бүлийн хүчирхийллийн хэргийн 1.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 1.0 пунктээр буурсан байна.

Зураг 2.7.4 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, хүчирхийллийн хэлбэрээр




Хүснэгт 2.7.1 Гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэд, хамаарлаар, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он

д/д	Хамаарал	нэгж	2015	2016	Өөрчлөлт	
					пункт	↑ ↓
1	Эхнэр	хувь	63.3	61.2	-2.1	↓
2	Нөхөр	хувь	3.4	5.5	2.1	↑
3	Хамтран амьдрагч	хувь	14.5	16.9	2.3	↑
4	Өвөг эцэг, эх	хувь	0.3	0.1	-0.2	↓
5	Төрсөн эцэг, эх	хувь	1.6	1.1	-0.5	↓
6	Хадам эцэг, эх, ах, эгч, дүү	хувь	1.7	1.5	-0.2	↓
7	Төрсөн эгч, ах	хувь	0.9	1.0	0.1	-
8	Төрсөн дүү	хувь	1.0	2.6	1.6	↑
9	Төрсөн хүүхэд	хувь	2.7	2.7	0.0	-
10	Үрчилж авсан хүүхэд	хувь	0.2	-	-	-
11	Дагавар хүүхэд	хувь	2.8	2.3	-0.5	↓
12	Төрөл төрөгсөд	хувь	7.7	5.4	-2.3	↓
13	Дүн	хувь	100.0	100.0	-	-

2.8 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН БАЙГУУЛЛАГА


Гэмт хэргийн улмаас 2016 онд нийт 84 байгууллага хохирсон нь өмнөх оноос 29 байгууллага буюу 25.7 хувиар буурчээ. Хохирогч байгууллагын тоо буурахад 2016 онд Улаанбаатар хотод гэмт хэргээс хохирсон байгууллагын тоо 21-ээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.8.1 Хохирсон байгууллага, 2007-2016 он



Байгууллагын төрлөөр нь авч үзвэл 2015 онд хохирсон байгууллагын 43.4 хувь нь төрийн, 8.8 хувь нь төрийн бус, 47.8 хувь нь хувийн байгууллага байгаа бөгөөд өмнөх оныхоос төрийн байгууллага 13.4 пункт, төрийн бус байгууллага 0.5 пунктээр буурч, хувийн байгууллага 13.9 пунктээр өссөн байна.


Зураг 2.8.2 Хохирсон байгууллага, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2007-2016 он



2016 онд нас барсан иргэдийн 9.9 хувийг 18-24 насныхан, 11.0 хувийг 25-29 насныхан, 10.8 хувийг 30-34 насныхан, 10.8 хувийг 35-39 насныхан эзэлж байна. Нас барсан иргэдийн тоо өмнөх оноос өсөхөд 45-49 насных 2.3 пункт, 7 хүртэлх насных 0.6 пункт, 14-17 насных 0.6 пункт, 30-34 насных 0.5 пункт, 25-29 насных 0.3 пунктээр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Нас барсан иргэдийн 246 буюу 28.0 хувь нь эмэгтэй, 112 буюу 12.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна.

Нас барсан 880 иргэний 90.2 хувь нь 24 цагийн дотор, 8.8 хувь нь 30 хоногийн дотор, 1.0 хувь нь 30-аас дээш хоногт амь насаа алджээ.

Зураг 2.9.2 Гэмт хэргийн улмаас нас барсан иргэд, хэргийн төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он




Гэмт хэргийн улмаас 2016 онд 847 хүн нас барсны 171 буюу 19.4 хувь нь хүнийг санаатай алах, 399 буюу 45.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмыг зөрчсөн, 203 буюу 23.1 хувь нь бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас амь насаа алджээ. Гэмт хэргийн улмаас 112 хүүхэд нас барж, 715 хүүхэд гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 2016 онд 11257 хүн гэмтсэн нь өмнөх оноос 30 хүн буюу 0.3 хувиар буурсан байна. Гэмтсэн иргэдийн 61.9 хувь нь эрэгтэйчүүд, 38.1 хувь нь эмэгтэйчүүд, 6.4 хувь нь хүүхдүүд байна. Нийт гэмтсэн хүмүүсийн 7947 буюу 70.6 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 81 буюу 0.7 хувь нь хүчингийн хэрэг, 1267 буюу 11.3 хувь нь танхайрах гэмт хэрэг, 1247 хүн буюу 11.1 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн байна.

Хүснэгт 2.9.2 Гэмтсэн иргэд, насны бүлгээр, 2010-2016 он

Насны бүлэг	Гэмтсэн хүний тоо							Дүнд эзлэх хувь						
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2010	2011	2012	2013	2014	2015	2016
7 хүртэлх	69	86	85	114	127	118	110	0.9	1.1	1.0	1.2	1.1	1.0	1.0
8-13	141	194	188	182	196	211	225	1.9	2.4	2.2	1.9	1.7	1.9	2.0
14-17	358	421	435	425	494	455	380	4.8	5.2	5.2	4.3	4.4	4.0	3.4
18-24	1 611	1 945	1 902	1 937	2 119	1 889	1 848	21.5	24.0	22.5	19.8	18.8	16.7	16.4
25-29	1 327	1 478	1 558	1 875	2 226	2 341	2 275	17.7	18.2	18.5	19.1	19.7	20.7	20.2
30-34	1 126	1 073	1 269	1 565	1 734	1 876	1 945	15.0	13.2	15.0	16.0	15.4	16.6	17.3
35-39	878	979	981	1 228	1 426	1 352	1 427	11.7	12.1	11.6	12.5	12.6	12.0	12.7
40-44	723	697	747	830	1 072	1 055	1 083	9.7	8.6	8.9	8.5	9.5	9.3	9.6
45-49	530	532	534	657	762	764	813	7.1	6.6	6.3	6.7	6.8	6.8	7.2
50-54	333	317	380	498	554	575	534	4.4	3.9	4.5	5.1	4.9	5.1	4.7
55-59	177	170	180	227	267	332	323	2.4	2.1	2.1	2.3	2.4	2.9	2.9
60-64	93	92	74	106	138	144	143	1.2	1.1	0.9	1.1	1.2	1.3	1.3
65-69	43	56	40	70	72	80	66	0.6	0.7	0.5	0.7	0.6	0.7	0.6
70 ба түүнээс дээш	77	60	63	83	94	95	85	1.0	0.7	0.7	0.8	0.8	0.8	0.8
Улсын дүн	7 486	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Гэмтсэн иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 2016 онд 18-44 насныхан зонхилон гэмтэж бэртсэн байна. Гэмтсэн иргэдийн тоо өмнөх оноос буурахад 14-17 насных 0.7 пункт, 25-29 насных 0.5 пункт, 50-54 насных 0.4 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 2.9.3 Гэмтсэн иргэд, гэмтлийн зэргээр, дүнд эзлэх хувиар, 2015-2016 он

2016 онд гэмт хэргийн улмаас гэмтсэн иргэдийн 78.8 хувь нь хөнгөн, 14.2 хувь нь хүндэвтэр, 7.0 хувь нь хүнд гэмтэл авсан байна.

Хүснэгт 2.9.3 Гэмтсэн иргэд, хэргийн төрлөөр, 2007-2016 он


д/д	Гэмт хэргийн төрлөөр	Гэмтсэн иргэд									
		2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	2	5	-	-	-	-	-	-	-
2	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4 437	5 182	5 479	4 600	4 868	5 371	6 288	7 561	7 712	7 947
3	Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг	-	3	6	1	1	1	-	-	2	2
4	Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	202	233	192	154	150	121	112	122	105	98
5	Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	36	45	35	31	46	58	81	103	103	87
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	374	919	365	233	265	258	276	295	240	253
7	Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	2	1	3	2	-	-	-	-	1
8	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1 497	1 496	1 284	1 242	1 416	1 302	1 465	1 434	1 418	1 270
9	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	190	236	243	238	195	177	220	215	238	281
10	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	1	2	1	1	-	1	2	6	-	1
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	945	892	920	933	1 094	1 078	1 282	1 460	1 382	1 247
12	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	46	60	40	42	55	57	64	71	75	56
13	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	10	6	2	4	5	1	8	8	6
14	Албан тушаалын гэмт хэрэг	7	2	7	-	-	-	-	-	1	1
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	13	12	9	6	4	7	6	6	3	7
Улсын дүн		7 759	9 096	8 593	7 486	8 100	8 436	9 797	11 281	11 287	11 257

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн улмаас 93.1 мянган иргэн гэмтсэний 59.5 мянга буюу 63.9 хувь нь Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг, 13.8 мянга буюу 14.8 хувь нь Нийгмийн аюулгүй байдлын эсрэг, 11.2 мянга буюу 12.1 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтэж бэртсэн байна. 2016 онд гэмтсэн иргэдийн тоо буурахад Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 148 (10.4%)-аар, ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэрэг 135 (9.8%)–аар өссөн нь голлон нөлөөлжээ.


2.10 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 онд 162.9 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 44.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 18.6 (12.9 %) тэрбум төгрөгөөр өсч, харин нөхөн төлүүлсэн хохирол 5.0 (10.3 %) тэрбум төгрөгөөр буурсан байна (Зураг 2.10.1).


Зураг 2.10.1 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, тэрбум төг, 2006-2016 он



Зураг 2.10.2 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмт хэргийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2007-2016 он




2016 онд хүнд гэмт хэргээс учирсан хохирол өмнөх оноос 15.3 пунктээр өсч, харин хүндэвтэр гэмт хэргээс учирсан хохирол 6.8 пункт, онц хүнд гэмт хэргээс учирсан хохирол 8.0 пункт, хөнгөн гэмт хэргээс учирсан хохирол 0.5 пунктээр буурчээ.

Зураг 2.10.3 Учирсан хохирол, бүсээр, хувиар, 2007-2016 он

Тайлбар: Бусдыг Улаанбаатар хотод оруулсан болно.

Жил тутам улсын хэмжээгээр гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 66.4-86.2 хувийг Улаанбаатар хот эзэлдэг байна. 2016 онд улсын хэмжээгээр нийт учирсан хохирлын 117.2 тэрбум төгрөг буюу 71.9 хувийг нийслэлд учирсан хохирол эзэлж байгаа нь өмнөх оноос 29.9 тэрбум төгрөг буюу 34.2 хувиар нэмэгдсэн байна. Нийслэлийн дүүргүүдээс Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүдэд хохирол хамгийн их учирчээ.

Зураг 2.10.4 Хохирлын нөхөн төлүүлэлт, хувиар, 2011-2016 он

Хүснэгт 2.10.1 Учирсан хохирол ба нөхөн төлүүлэлт, Улаанбаатар хотын дүүргүүдээр, сая төгрөг, 2014-2016 он

	Учирсан хохирол			Нөхөн төлүүлэлт		
	2014	2015	2016	2014	2015	2016
Баянгол	47 162.5	14 863.1	18 572.0	3 284.8	5 390.1	4 912.9
Баянзүрх	23 847.4	11 909.2	14 445.5	5 142.9	3 614.7	4 491.6
Сүхбаатар	17 572.7	19 152.6	14 436.1	2 689.1	4 726.9	4 792.3
Сонгино хайрхан	8 358.6	8 067.5	5 544.8	6 386.7	3 384.6	2 649.3
Хан-Уул	7 758.7	6 879.4	4 556.9	3 742.7	5 163.2	2 283.3
Чингэлтэй	11 606.9	24 357.2	58 493.3	3 022.6	2 526.7	3 775.8
Бага нуур	139.5	450.3	279.3	96.5	120.4	123.5
Бага хангай	97.6	396.9	51.6	93.6	384.7	47.0
Налайх	1 202.3	1 232.4	795.1	871.1	639.7	455.1
Нийслэлийн дүн	117 746.2	87 308.5	117 174.6	25 330.0	25 951.0	24 530.7


Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 онд 117.2 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 24.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 29.9 (34.2 %) тэрбум төгрөгөөр өсч, харин нөхөн төлүүлсэн хохирол 1.4 (5.5 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийслэлд гэмт хэргийн улмаас 2016 онд учирсан хохирлын 49.9 хувь нь Чингэлтэй, 12.3 хувь нь Сүхбаатар, 15.8 хувь нь Баянгол, 12.3 хувь нь Баянзүрх дүүрэгт байна. Дүүргүүдээс Бага хангай дүүрэг 91.1%, Хан-Уул дүүрэг учирсан хохирлынхоо 50.1%, Налайх 57.2 %, Сонгино хайрхан 47.8 %, Чингэлтэй 6.5 % нөхөн төлүүлсэн байна.

2.11 ЭРҮҮЛЖҮҮЛЭГДСЭН, БАРИВЧЛАГДСАН ИРГЭД

2016 онд 87.4 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оноос 10.2 мянга буюу 10.5 хувиар буурсан байна.

Зураг 2.11.1 Эрүүлжүүлэгдсэн нийт хүн, мянган хүнээр, 2006-2016 он



Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж эрүүлжүүлэгдсэн 87.4 мянган хүний 48.7 мянга буюу 55.7 хувь нь нийслэлд, 34.9 мянга буюу 40.0 хувь нь аймгуудад, 2.6 буюу 2.9 хувь нь төмөр замын цагдаагийн газарт эрүүлжүүлэгдэж, үйлчилгээний төлбөрт нийт 270.9 сая төгрөгийг төлсөн байна.

Зураг 2.11.2 Эрүүлжүүлэгдсэн иргэд, саатуулагдсан шалтгаанаар




Эрүүлжүүлэгдсэн хүний тоо өмнөх оноос 10.2 мянгаар буурахад Улаанбаатар хот 7393(13.2 %), аймгуудаас Дорнод 729(15.0%), Баянхонгор 708(27.1 %), Ховд 701(28.3%)-ээр буурсан нь голлон нөлөөлжээ.


Эрүүлжүүлэгдсэн иргэдийн 4925 буюу 5.6 хувь нь эмэгтэйчүүд, 279 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 74 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүс байна.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 66617 буюу 76.3 хувь нь ажилгүй иргэд, 7691 буюу 8.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 826 буюу 0.9 хувь нь ажилчин, малчин, 1634 буюу 1.9 хувь нь хувийн хэвшилд ажиллагчид, 414 буюу 0.5 хувь нь оюутан, сурагчид, 1039 буюу 1.2 хувь нь төрийн албан хаагчид байна. 2016 онд эрүүлжүүлэгдсэн иргэдийн 393 буюу 0.4 хувийг нь архины албадан эмчилгээнд хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 54 буюу 15.9 хувиар нэмэгдсэн байна. Архины сайн дурын эмчилгээнд 755 хүн хамрагдсан нь өмнөх оноос 252 буюу 50.1 хувиар өссөн байна.

Зураг 2.11.3 Эрүүлжүүлэгдсэн иргэд, согтолтын зэргээр, 2015-2016 он



Зураг 2.11.2 Эрүүлжүүлэгдсэн иргэд, бүсээр, хувиар, 2010-2016 он



Тайлбар: Албадан саатуулах төв болон Төмөр замыг Улаанбаатар хотын дүнд хамруулсан болно.


Нийт эрүүлжүүлэгдсэн иргэдийн 48.7 мянга буюу 55.7 хувь нь Улаанбаатар хотынх байна. Дүүргүүдээс 2016 онд Баянзүрх(11166), Сонгинохайрхан(9694) дүүргүүдэд хамгийн олон хүн эрүүлжүүлэгдсэн байна.

Хүснэгт 2.11.1 Эрүүлжүүлэгдсэн хүн, аймаг, бүсээр, 2010-2016 он

Аймаг, нийслэл	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Улсын дүн	109 799	115 349	118 030	123 454	119 015	97 560	87 356
Баруун бүс	10 114	9 988	10 987	9 667	8 433	5 596	4 539
Баян-Өлгий	850	1 340	1 079	1 236	1 143	620	739
Говь-Алтай	1 426	1 551	1 086	1 116	880	759	636
Завхан	1 917	1 308	2 852	1 713	1 234	772	619
Увс	1 784	1 639	2 051	2 370	2 041	967	768
Ховд	4137	4 150	3 919	3 232	3 135	2 478	1 777
Хангайн бүс	11 259	11 989	12 191	12 539	12 132	11 972	11 194
Архангай	1 149	1 212	856	576	486	870	770
Баянхонгор	982	1 212	1 530	2 144	2 591	2 611	1 903
Булган	769	732	692	804	796	570	567
Орхон	4 527	4 675	5 404	5 165	5 005	5 020	4 854
Өвөрхангай	1 300	1 760	1 516	1 670	924	933	1 272
Хөвсгөл	2 532	2 398	2 193	2 180	2 330	1 968	1 828
Төвийн бүс	16 620	18 890	19 522	19 772	17 686	14 165	13 254
Говьсүмбэр	1 179	946	985	1 541	1 431	1 150	877
Дархан-Уул	5 377	5 498	5 642	5 444	5 836	5 869	6 183
Дорноговь	2 333	3 141	3 426	3 524	2 383	1 538	1 450
Дундговь	830	1 353	928	1 158	943	471	513
Өмнөговь	1 988	1 755	2 504	2 753	2 482	1 212	670
Сэлэнгэ	3 874	5 118	4 716	4 015	3 456	2 774	2 501
Төв	1 039	1 079	1 321	1 337	1 155	1 151	1 060
Зүүн бүс	13 975	13 106	13 168	13 744	12 430	6 785	5 919
Дорнод	7 613	7 770	7 199	7 226	7 229	4 867	4 138
Сүхбаатар	2 772	2 849	3 098	2 840	1 994	633	520
Хэнтий	3 010	2 487	2 871	3 678	3 207	1 285	1 261
Улаанбаатар	58 411	61 376	62 162	67 732	68 334	59 042	52 450

2016 онд 1.3 сая захиргааны зөрчил гарсан нь өмнөх оноос 388.5 мянгаар буурчээ. Захиргааны зөрчил гаргасан 1 сая гаруй иргэн, 1167 аж ахуйн нэгжээс 30.6 тэрбум төгрөгийн торгуул төлүүлсэн байна. 2016 онд захиргааны зөрчлийн улмаас 5.4 мянган хүн баривчлагдсан нь 2015 оноос 7.8 мянга буюу 59.2 хувиар буурсан байна. 2016 онд захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан иргэдийн 2413 буюу 55.1 хувь нь аймгуудынх, 2963 буюу 55.1 хувь нь нийслэлд ногдож байна.

Зураг 2.11.4 Баривчлагдсан нийт иргэд, 2005-2016 он



БҮЛЭГ 3. ШҮҮХИЙН СТАТИСТИК

3.1 АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасанчлан Шүүх гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс гаргадаг **шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг** ойлгоно.

“Дагнасан шүүх” гэж Эрүү, Иргэн, Захиргааны хэргийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг ойлгоно.

Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.

Анхан шатны шүүхээр 2016 онд 5762 эрүүгийн хэрэг, 46173 иргэний хэрэг, 1780 захиргааны хэрэг хянан шийдвэрлэгдэж, 7003 захиргааны зөрчилд хариуцлага ногдуулж, 945 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллаж, 3642 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ Хүснэгт(3.1.1). Анхан шатны шүүхээр 2016 онд 60718 хэрэг, зөрчил шийдвэрлэгдсэн нь өмнөх оноос 3064 хэрэг буюу 4.8 хувиар буурсан байна.


Хүснэгт 3.1.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг, 2011-2016 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016
Эрүүгийн хэрэг	5877	6161	6169	6375	6756	5 762
Иргэний хэрэг	30368	27792	35314	33996	40674	46 173
Захиргааны хэрэг	891	961	1106	1187	1439	1 780

Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр 2016 онд 7025 эрүүгийн хэрэг ирсэний 5762 буюу 82.0 хувь нь шийдвэрлэгдэж, 693 буюу 9.9 хувь нь мөрдөн байцаалтанд буцаж, 39 буюу 0.6 хувь нь

хэрэг бүртгэлд буцаж, 22 буюу 0.3 хувь нь харьяаллын дагуу шилжсэнээр 511 буюу 7.3 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Зураг 3.1.1 Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн бүтэц, оноор




Хүснэгт 3.1.2 Анхан шатны шүүхийн эрүүгийн хэрэг, 2009-2016 он

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Хэргийн тоо-бүгд	6 304	6 372	6 776	7 065	7 248	7 603	7 998	7025
Мөрдөн байцаалтанд буцаасан	455	445	440	465	495	694	694	693
Хэрэг бүртгэлд буцаасан	27	70	8	7	10	18	42	37
Харьяаллын дагуу шилжүүлсэн	3	11	13	12	12	23	23	22
Шийдвэрлэсэн	5 407	5 460	5 877	6 161	6 169	6 375	6 756	5 762
Тайлант хугацааны үлдэгдэл	412	386	438	420	562	493	483	511


Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэхээр ирсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 973 буюу 12.2 хувиар буурсан байна. Нийт шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 2.4 пунктээр буурч, харин мөрдөн байцаалтанд буцаасан болон тайлант хугацааны эцсийн үлдэгдэл хэрэг 1.2 пунктээр өссөн байна.

2016 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн 2491 буюу 43.2 хувь нь Улаанбаатар хотынх байна. Аймгуудаас Төв, Хөвсгөл, Дархан-уул, Орхон аймгуудад хамгийн олон хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ.

Зураг 3.1.2 Анхан шатны шүүхээр хамгийн олон Эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэн аймгууд, 2016 он




Зураг 3.1.3 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, 2009-2016 он



Жил тутам анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн хэргийн 80 гаруй хувь нь шийдвэрлэгддэг байна. Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 973 буюу 12.2 хувь, шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 6 буюу 0.1 хувиар буурсан байна Зураг 3.1.3.

Зураг 3.1.4 Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, төрлөөр, 2015-2016 он




Хүснэгт 3.1.3 Анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, 2009-2016 он


Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Ял шийтгүүлсэн хүн	7 513	7 292	8 210	8 324	8 065	8 178	7 696	6 566
Урьд нь ял шийтгүүлсэн	1 637	1 645	1 460	1 544	1 698	1 919	1 900	1 773
Гэмт хэрэг давтан үйлдсэн	591	562	471	539	504	455	600	451
Бүлэглэн үйлдсэн	1 314	1 407	1 465	1 498	1 414	1 604	1 616	1 382
Согтуугаар үйлдсэн	1 610	1 512	1 704	1 717	1 710	1 582	1 700	1 729

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2016 онд 6566 болж, өмнөх оноос 1130 буюу 14.7 хувиар буурсан байна. Тухайн жилд сэжигтэн, яллагдагчаар татагдсан иргэдийн 27.6 хувь нь ял шийтгүүлсэн бөгөөд өмнөх оноос 3.4 пунктээр буурсан байна.

Ял шийтгүүлэгчдийн 1773 буюу 27.0 хувь нь урьд нь ял шийтгүүлж байсан, 451 буюу 6.9 хувь нь давтан хэрэг үйлдсэн, 1382 буюу 21.0 хувь нь бүлэглэн үйлдсэн, 1729 буюу 26.3 хувь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлэгчдийн 518 буюу 7.9 хувь нь эмэгтэйчүүд, 360 буюу 5.5 хувь нь хүүхдүүд байна.

Зураг 3.1.4 Шүүхээр ял шийтгүүлсэн эмэгтэйчүүд, 2005-2016 он

2016 онд шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн 46.3 хувийг 18-29 насны залуучууд, 18.1 хувийг 30-34 насныхан, 30.2 хувийг 35-аас дээш насныхан, 5.5 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл ял шийтгүүлсэн 35-аас дээш насныхан өмнөх оноос 0.1 пункт, 30-34 насныхан 1.1 пунктээр өсч, харин бусад насны бүлгүүд буурсан байна. Ял шийтгүүлэгчдийн 35 буюу 0.5 хувь нь 55-аас дээш насны эмэгтэйчүүд байна.

Зураг 3.1.5 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, насны бүлгээр, 2015-2016 он


2016 онд шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн 44.1 хувь нь бүрэн дунд, 19.3 хувь нь суурь, 11.3 хувь нь бага боловсролтой байна. Шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн 9 буюу 0.1 хувь нь улс төрийн албан тушаалтан, 37 буюу 0.6 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 81 буюу 1.2 хувь нь төрийн тусгай албан хаагч, 144 буюу 2.2 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 454 буюу 6.9 хувь нь оюутан, сурагчид, 4111 буюу 62.6 хувь нь ажил эрхлээгүй хүмүүс байна.

Ял шийтгүүлсэн иргэдийн 6546 буюу 99.7 хувь нь Монгол улсын иргэд, 19 буюу 0.3 хувь нь гадаадын иргэд байна. 2016 онд ял шийтгүүлсэн 6566 хүний 5114 буюу 77.9 хувьд нь хорих ял оногдуулж, 1823 буюу 35.6 хувь нь хорих ялыг биечлэн эдэлж, 2866 буюу 56.0 хувь нь тэнсэж, 217 буюу 4.2 хувьд нь тогтоол биелүүлэхийг түдгэлзүүлж, 122 буюу 2.4 хувьд нь өршөөл үзүүлсэн байна.

2016 онд 733 хүн баривчлах ялаар, 376 хүн албадан ажил хийлгэх ялаар, 216 хүн торгуулийн ялаар шийтгүүлсэн нь баривчлах ял шийтгүүлэгчид өмнөх оноос 224 (23.4%), албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлэгчид 87(18.8/%), торгуулийн ял шийтгүүлэгчид 154(41.6%)-өөр буурсан байна.

Зураг 3.1.6 Шүүхээр ял шийтгүүлсэн иргэд, боловсролын түвшнээр, хувиар,


2015-2016 он

**Хүснэгт 3.1.4 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргээс учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2016 он**

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг	Ял шийтгүүлсэн иргэд	Учирсан хохирол, сая төгрөг	Нөхөн төлүүлсэн хохирол, сая төгрөг	Нөхөн төлүүлэлтийн хувь
2007	5 831	8 463	67 035.3	1 154.7	1.7
2008	5 812	8 494	14 927.6	9 671.9	64.8
2009	5 407	7 513	19 440.5	1 184.0	6.1
2010	5 460	7 292	26 312.8	1 955.4	7.4
2011	5 877	8 210	13 854.6	1 707.6	12.3
2012	6 161	8 324	21 981.9	2 065.0	9.4
2013	6 169	8 065	95 896.2	90 822.9	94.7
2014	6 375	8 178	78 169.4	1 483.0	1.9
2015	6 756	7 696	59 796.1	1 348.8	2.3
2016	5 762	6 566	15 230.3	1 151.0	7.6

2016 оны байдлаар шүүхээр 5762 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдэж, 15.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 3.1.7 Учирсан хохирол, нөхөн төлүүлэлт, 2007-2016 он



Улсын хэмжээнд 2016 онд нийт учирсан нийт хохирлын 7.6 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 5.3 пунктээр өссөн байна.

3.2 АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРЭГ

Анхан шатны шүүх 2016 онд 64.0 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11.2 мянган нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 46.2 мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Энэ нь өмнөх оноос 5.5 мянга буюу 13.5 хувиар өссөн байна. Иргэний хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн 86.0 хувийг эзэлж өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна.


Иргэний хэрэг өмнөх оноос өсөхөд худалдах, худалдан авах арилжаатай холбоотой маргаан 1810 (32.1%-аар, зээлийн гэрээний маргаан 1184(19.1%-өөр, банк, зээлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан 554(30.7%-өөр, ажлаас үндэслэлгүй халсан маргаан 303 (33.2%-аар, цалин хөлсний маргаан 238 (57.3%-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс энэ онд шийдвэрлэсэн хэргүүдийн 51.6 хувийг Улаанбаатар хот дахь анхан шатны шүүхүүд шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 7.0 пунктээр буурсан байна.

2016 онд шүүхээр шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 35.1 хувийг ИХШХШХ-ийн 74-р зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар, 51.0 хувийг ИХШХШХ-ийн 115-р зүйлд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэж, 13.9 хувийг ИХШХШХ-ийн 117-р зүйлийн дагуу хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 3.2.1 Шийдвэрлэгдсэн иргэний хэрэг, хуулиар, 2011-2016 он


Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016
Нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг	30 368	27 792	35 314	33 996	40 674	46 173
Иргэний хуулиар	11568	11 796	12 738	14 708	20 805	24 826
ИХШХШ хуулиар	11 152	9 262	15 571	12 421	11 532	11 942
Гэр бүлийн тухай хуулиар	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674
Хөдөлмөрийн тухай хуулиар	897	742	1 080	1 377	1 487	2 220
Газрын тухай хуулиар	101	142	93	132	198	148
Дампуурлын тухай хуулиар	7	37	11	13	16	10
Компаны тухай хуулиар	24	16	18	8	18	32
Нийгмийн даатгалын багц хуулиар	128	97	148	326	436	476
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар	210	147	162	118	204	381
Татварын ерөнхий хуулиар	283	251	412	305	621	574
Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	5	2	6	4	-	1
Төрийн албаны тухай хуулиар	6	4	2	3	7	4
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулиар	70	73	52	55	44	45
Бусад	1 439	1 378	678	319	767	840

Зураг 3.2.1 Иргэний хэрэг, маргааныг шийдвэрлэсэн байдал, 2015-2016 он

Шийдвэрлэсэн иргэний хэргийн 24.8 мянга буюу 53.8 хувь нь Иргэний хуулиар, 11.9 мянга буюу 25.9 хувь нь ИХШХШ хуулиар, 4.7 мянга буюу 10.1 хувь нь Гэр бүлийн тухай хуулиар, 2.2


мянга буюу 4.8 хувь нь Хөдөлмөрийн тухай хуулиар, 2.5 мянга буюу 5.4 хувийг бусад хуулиар шийдвэрлэгджээ.

Зураг 3.2.1 Шийдвэрлэсэн иргэний хэрэг, хуулиар, 2015-2016 он



Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2016 онд 2220 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 1213 буюу 54.6 хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 653 буюу 29.4 хувь нь цалин хөлсний маргаан, 59 буюу 2.7 хувь нь ажлаас буруу шилжүүлсэн маргаан бөгөөд өмнөх оноос ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 6.6 пунктээр буурч, харин цалин хөлсний маргаан 1.5 пункт, ажлаас буруу шилжүүлсэн маргаан 1.5 пунктээр өссөн байна.

Зураг 3.2.2 Шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргаан, бүс, нийслэлээр, 2010-2016 он



2016 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хөдөлмөрийн маргааны 16.8 хувь нь баруун бүсэд, 10.4 хувь нь хангайн бүсэд, 12.6 хувь нь төвийн бүсэд, 2.4 хувь нь зүүн бүсэд, 57.9 хувь нь Улаанбаатар хотод байна. Шүүхээр шийдвэрлүүлсэн нийт хөдөлмөрийн маргаанд баруун бүсийнх өмнөх оноос 2.2 пункт, хангайн бүс 0.6 пункт, зүүн бүс 0.9 пункт, Улаанбаатар хот 1.1 пунктээр буурч, харин төвийн бүсийнх 0.9 пунктээр өссөн байна.

Хөдөлмөрийн маргаан 2015 оныхоос 733 буюу 49.3 хувиар нэмэгдэхэд ажлаас үндэслэлгүй халах маргаан 303 (33.3%), цалин хөлсний маргаан 238(57.3%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын “Дампуурлын тухай” хуулиар 2016 онд 10 аж ахуйн нэгж шүүхийн шийдвэрээр дампуурлаа зарласан бөгөөд эдгээрийн 5 (50.0%) аж ахуйн нэгжийнх нь хариуцагчийг татан буулгаж, 1 (10.0%) аж ахуйн нэгжийнх нь хариуцагчийг дахин хөрөнгөжүүлсэн байна.


Хүснэгт 3.2.2 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэгдсэн хэрэг, 2011-2016 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016
Улсын дүн	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674
Гэрлэлт цуцалсан	3 642	3 100	3 382	3 182	2 978	2 980
Эцэг тогтоосон	325	278	313	430	531	450
Эцэг, эх байх эрх хассан	7	4	6	21	37	17
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	364	370	454	478	825	1 006
Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	9	11	11	32	59	47
Бусад	102	115	110	64	109	174

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2016 онд 4674 хэрэг шийдвэрлэгдсэний 2980 (63.8%) нь гэрлэлт цуцалсан, 450 (9.6%) нь эцэг тогтоосон, 1006 (21.9%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 17 (0.4%) нь эцэг, эх байх эрх хассан, 47 (1.0%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 174 (3.7%) нь бусад хэрэг байна.

“Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өмнөх оноос 115 (3.0%)-аар өсөхөд хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хэрэг 181(21.9%)-ээр, бусад хэрэг 73 (59.6%) өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 3.2.2 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн хэргийн бүтэц, 2015-2016 он



2016 онд 1006 хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэрэг шийдвэрлэгдэж, 1060 хүүхэд тэтгэлэг тогтоолгосон нь өмнөх оноос хүүхдийн тэтгэлэг гаргуулах хэргийн тоо өссөн хэдий ч хүүхдийн тоо 882-оор буурсан байна.

3.3 АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Захиргааны хэрэг гэдэг нь бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.


Хүснэгт 3.3.1 Анхан шатны шүүхийн захиргааны хэрэг, 2011-2016 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016
Нийт дүн	891	961	1 097	1 187	1439	1 780
Ашигт малтмалтай холбоотой маргаан	86	119	72	43	96	142
Байгал орчныг хамгаалахтай холбоотой маргаан	1	4	3	2	2	3
Боловсролтой холбоотой маргаан	2	2	3	4	4	1
Газрын маргаан	228	210	280	386	338	419
Иргэний бүртгэлтэй холбоотой маргаан	27	18	13	28	16	30
Нийгмийн даатгалтай холбоотой маргаан	24	11	16	23	37	40
Оюуны өмчийн маргаан	6	1	3	4	6	2
Сонгуулийн маргаан	10	120	103	14	6	184
Татварын маргаан	76	73	65	81	128	127
Тендерийн маргаан	38	42	34	40	55	68
Төрийн албаны маргаан	139	133	203	297	400	417
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	11	18	16	9	11	6
Төрийн хяналт, шалгалттай холбоотой бусад маргаан	54	42	46	81	83	75
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад маргаан	19	7	2	15	15	10
Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бусад маргаан	12	5	6	12	14	24
Үнэт цаасны маргаан	5	1	3	-	-	2
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	83	80	88	59	104	83
Бусад	70	75	141	89	124	147
Нэхэмжлэгч-бүгд	1 045	1 001	1 150	1 398	1 651	2 041
Иргэд	685	590	689	955	1 089	1 293
Хуулийн этгээд	360	411	461	443	562	748


Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2016 онд нийт 3234 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас 810 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, буцаах, шилжүүлэх ажиллагаа хийж, 1780 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2016 онд 2041 нэхэмжлэгчид холбогдох 1780 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос нэхэмжлэгчдийн тоо 390(23.6%)-ээр, харин хэргийн тоо 341(23.7%)-ээр өссөн байна. Нийт нэхэмжлэлийн 1293(63.4%) нь иргэний нэхэмжлэл, 748 (36.6%) нь хуулийн этгээдийн нэхэмжлэл байна. Нийт маргааны 1079 (60.6%) нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдсэн байна. Захиргааны хэрэг өсөхөд газрын маргаан 81-ээр, сонгуулийн маргаан 178-аар өссөн нь голлон нөлөөлжээ. 2015 онд шийдвэрлэгдсэн 1439 хэргийн 926 буюу 64.4 хувь нь нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг байна.

**Зураг 3.3.1 Анхан шатны шүүхийн захиргааны хэрэг, шийдвэрлэсэн байдлаар,
2015-2016 он**




Зураг 3.3.1 Анхан шатны шүүхийн захиргааны хэргийн хариуцагч, байгууллагаар, 2014-2015 он



3.4 ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ


Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2016 онд 1961 хэрэг хүлээн авч, 1822 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 149(7.6%)-өөр буурчээ.

Зураг 3.4.1 Давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, хувиар, 2013-2016 он



Давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоолыг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх оноос 3.9 пунктээр өсч, харин тогтоолыг хүчингүй болгосон нь 1.3 пункт, тогтоолд өөрчлөлт оруулсан нь 2.7 пунктээр буурсан байна.

Зураг 3.4.2 Давж заалдах шатны шүүхээр тогтоолыг хүчингүй болгосон хэрэг, хувиар, оноор




Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2016 онд 3475 хэрэг хүлээн авч, 3108 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 589 (23.4%)-өөр өссөн байна.

Хүснэгт 3.4.1 Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2013-2016 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016
Нийт хүлээн авсан хэрэг	2 011	2 116	2 800	3 475
Нийт шийдвэрлэсэн хэрэг	1 806	1 962	2 540	3 143
Хянан шийдвэрлэсэн -бүгд	1 837	1 947	2 519	3 108
Арбитрийн шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн	15	5	7	13
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	16	10	14	22
Давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзсан	36	46	69	54
Давж заалдах гомдлоосоо татгалзсан	36	13	40	44
Үлдэгдэл хэрэг	103	95	151	234

Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Зураг 3.4.2 Давж заалдах шатны шүүхийн иргэний хэргийн шийдвэрлэлт, хувиар, 2013-2016 он



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээр 2016 онд тогтоолыг хэвээр үлдээсэн хэрэг өмнөх оноос 0.2 пункт, тогтоолыг хүчингүй болгосон хэрэг 2.1 пунктээр буурч, харин тогтоолд өөрчлөлт оруулсан хэрэг 2.3 пунктээр өссөн байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2016 онд 1555 хэрэг хүлээн авч, 1460 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 411(39.2%)-ээр өссөн байна.

Хүснэгт 3.4.2 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2013-2016 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016
Нийт хүлээн авсан хэрэг	660	933	1 126	1 555
Хянан шийдвэрлэсэн -бүгд	598	883	1 049	1 460
Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан	384	512	606	823
Анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан	185	343	416	573
Бусад	26	25	25	60
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	3	3	2	4
Үлдэгдэл хэрэг	62	50	77	95


Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Давж заалдах шатны Захиргааны хэргийн шүүхээр 2016 онд 1460 хэрэг шийдвэрлэсний 823 (56.4%) нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан, 573 (39.2%) нь анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан, 4 (0.3%) нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан байна.

3.5 ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ.


Хяналтын шатны шүүх 2016 онд 448 эрүүгийн хэрэг, 1655 иргэний хэрэг, 548 захиргааны хэрэг, нийт 2651 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 342(14.8%)-оор өссөн байна.

Зураг 3.5.1 Хяналтын шатны шүүхийн хэргийн бүтэц, дүнд эзлэх хувиар



2016 онд хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн 62.4 хувийг иргэний хэрэг, 16.9 хувь нь эрүүгийн хэрэг, 20.7 хувь нь захиргааны хэрэг байгаа бөгөөд иргэний хэрэг өмнөх оноос 2.8 пункт, захиргааны хэрэг 2.5 пунктээр өсч, харин эрүүгийн хэрэг 5.3 пунктээр буурсан байна.

Зураг 3.5.2 Хяналтын шатны шүүхийн хэргийн шийдвэрлэлт, 2015-2016 он




БҮЛЭГ 4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХИЙН СТАТИСТИК**Хүснэгт 4.1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн нөхөн төлүүлэлт, 2010-2016 он**

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016
	сая төгрөг						
Эрүүгийн хэргийн							
Гүйцэтгэвэл зохих	8 771.1	15 515.8	18 753.8	34 370.7	44 376.0	177 701.1	170 540.0
Гүйцэтгэсэн	3 010.5	3 026.0	5 293.1	4 863.0	7 059.8	17 702.9	10 611.6
Дуусгавар болгосон	1 524.3	2 402.4	4 407.9	4 213.8	3 742.4	13 705.4	8 260.4
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	1 486.2	623.6	643.8	493.9	333.2	3 997.4	2 351.2
Иргэний хэргийн							
Гүйцэтгэвэл зохих	183 595.2	173 329.9	196 630.5	364 875.0	644 246.7	626 900.5	907 783.5
Гүйцэтгэсэн	79 138.7	80 337.8	81 997.1	88 988.8	270 205.3	123 596.4	137 193.3
Дуусгавар болгосон	44 833.8	62 381.7	65 680.0	57 640.0	178 363.0	102 459.9	117 109.4
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	34 304.9	17 956.1	15 093.6	26 321.3	25 571.9	21 136.5	20 083.9
Захиргааны хэргийн							
Гүйцэтгэвэл зохих	174.2	199.2	56.3	99.8	86.4	1 247.1	1 763.7
Гүйцэтгэсэн	123.1	156.2	53.9	99.2	60.8	684.0	1 322.6
Дуусгавар болгосон	117.0	152.1	53.7	99.2	60.8	650.1	1 296.5
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	6.1	4.1	0.2	-	-	33.9	26.2
Бусад хэргийн							
Гүйцэтгэвэл зохих	193 251.4	188 974.7	8 314.1	424 386.4	151 827.7	43 125.1	138 560.7
Гүйцэтгэсэн	82 981.8	83 417.4	2 462.2	413 535.8	55 735.5	26 247.5	543.2
Дуусгавар болгосон	47 099.6	64 829.2	1 925.4	413 360.2	52 193.7	26 000.6	489.4
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	35 882.2	18 588.2	536.8	175.6	3 541.8	246.9	53.8

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Шүүхийн шийдвэрийн дагуу 2016 онд эрүүгийн хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 10.6 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 6.2 хувийг, иргэний хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 137.2 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 15.1 хувийг, захиргааны хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 1.3 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 75.0 хувийг, бусад хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 543.2 сая төгрөг болж, төлвөл зохих хохирлын 0.4 хувийг тус тус нөхөн төлүүлсэн байна. 2015 онд улсын хэмжээгээр шүүхийн шийдвэрийн дагуу гүйцэтгэвэл зохих учирсан хохирлын 19.8 хувийг нөхөн төлүүлсэн бол 2016 онд 12.3 хувийг нөхөн төлүүлж, нийт гүйцэтгэсэн нөхөн төлүүлэлт өмнөх оноос 7.5 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт эрүүгийн хэргийн хувьд жил бүр бага байдаг ба энэ нь хэрэгт холбогдогчдын төлбөрийн чадвар муу, нөгөөтэйгүүр ажилгүй иргэд гэмт хэрэгт их холбогдогдож байгаатай холбоотой гэж үзэж болох талтай.

Зураг 4.1.1 Шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн нөхөн төлүүлэлтийн хувь, 2012-2016 он



Хүснэгт 4.1.2 Хорихоос өөр төрлийн ял, 2012-2015 он

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016
Торгох ял, сая төгрөг					
Гүйцэтгэвэл зохих	1 306.8	1 448.3	1 288.1	585.8	465.5
Гүйцэтгэсэн	851.7	1 100.5	955.9	581.8	314.0
Дуусгавар болгосон	619.4	864.5	688.5	455.8	234.7
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	232.3	236.0	267.4	125.9	79.3
Эрх хасах ял, хоног					
Гүйцэтгэвэл зохих	302 563	517 812	777 323	433 251	292 340
Гүйцэтгэсэн	142 741	269 431	374 762	411 920	108 478
Дуусгавар болгосон	39 390	74 104	56 720	98 220	9 367
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	103 351	195 327	318 042	313 700	99 111
Албадан ажил хийлгэх ял, цагаар					
Гүйцэтгэвэл зохих	130 487	134 317	117 346	112 411	91 924
Гүйцэтгэсэн	124 590	127 564	109 577	109 058	83 683
Дуусгавар болгосон	107 772	97 352	73 994	79 591	54 894
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	16 818	30 212	35 583	29 467	28 789
Эд хөрөнгө хураах ял, сая төгрөг					
Гүйцэтгэвэл зохих	95.8	224.3	244.5	248.1	56.8
Гүйцэтгэсэн	55.7	193.9	221.9	231.2	41.2
Дуусгавар болгосон	54.1	178.3	157.8	229.2	36.2
Хэсэгчлэн гүйцэтгэсэн	1.6	15.6	64.1	2.0	5.0

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

5. УЛС ОРНУУДЫН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ, БАЙДЛААС

Хүснэгт 5.1.1 100 000 хүнд ногдох хулгайн гэмт хэрэг, Азийн сонгосон улсаар, 2005-2014 он

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	
Казакстан	хэргийн тоо	63 141	59 338	51 497	52 671	48 961	59 939	121 602	178 426	210 176	-
	100 000 хүнд ногдох	408.6	380.3	326.9	330.9	304.1	367.5	734.6	1 060.7	1 229.1	
Киргизстан	хэргийн тоо	12 335	10 967	11 185	10 963	10 936	9886	12 008	10 848	9 975	9 029
	100 000 хүнд ногдох	241.1	212.3	213.9	206.8	203.3	180.9	216.2	192.1	173.6	154.5
Тажикстан	хэргийн тоо	3 558	3 156	3 737	3 233	3 465	3 559	3 669	-	-	-
	100 000 хүнд ногдох	52.3	45.4	52.6	44.6	46.7	46.9	47.3	-	-	-
Япон	хэргийн тоо	923 309	811 250	744 066	720 609	658 739	618 088	582 767	546 088	497 676	451 648
	100 000 хүнд ногдох	727.1	638.1	584.7	566.0	517.3	485.5	458.0	429.5	391.9	356.2
Монгол	хэргийн тоо	6 683	6 657	7 927	6 609	6 376	5 777	5 276	6 266	7 884	8 424
	100 000 хүнд ногдох	264.5	260.2	305.7	251.3	238.8	213.0	191.2	223.1	275.7	289.5
Солонгос	хэргийн тоо	188 780	192 555	212 342	223 207	256 418	269 410	281 359	290 055	288 343	266 222
	100 000 хүнд ногдох	396.5	402.0	440.5	460.1	525.4	548.8	570.1	584.7	578.5	531.7
Сингапур	хэргийн тоо	21 168	19 073	18 068	18 360	18 998	18 274	17 251	17 462	16 124	15 868
	100 000 хүнд ногдох	470.9	413.3	381.8	378.6	382.6	359.8	332.3	329.5	298.3	288.2
Тайланд	хэргийн тоо	60 881	63 649	62 000	57 452	50 412	54 330	45 030	45 183	43 654	39 898
	100 000 хүнд ногдох	92.4	96.2	93.4	86.5	75.8	81.5	67.3	67.3	64.7	58.9
Азербайджан	хэргийн тоо	2 151	2 139	1 903	3 347	3 640	3 868	5 019	4 236	5 144	5 861
	100 000 хүнд ногдох	25.1	24.7	21.7	37.7	40.5	42.5	54.4	45.2	54.2	60.9

Эх үүсвэр: <https://www.unodc.org/>

2014 оны байдлаар Азийн сонгосон улс орнуудаас 100 000 хүнд ногдох хулгайн гэмт хэрэг Солонгос (531.7), Япон (356.2), Монгол(289.5) Сингапур(288.2) улсуудад хамгийн өндөр байна.


Хүснэгт 5.1.2 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, Азийн сонгосон улсаар, 2006-2013 он

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Монгол	хэргийн тоо	-	187	127	147	144	163	200
	100 000 хүнд ногдох	-	20.9	14.3	16.5	16.2	18.1	21.8
Казакстан	хэргийн тоо	84	101	84	95	100	148	475
	100 000 хүнд ногдох	1.8	2.2	1.8	2.0	2.1	3.1	9.6
Гонконг	хэргийн тоо	621	781	834	752	810	718	584
	100 000 хүнд ногдох	51.5	66.8	73.0	67.0	73.1	65.8	54.3
Япон	хэргийн тоо	5 342	4 791	4 386	4 111	4 307	4 124	4 356
	100 000 хүнд ногдох	25.2	22.8	21.1	19.9	21.0	20.2	21.4
Солонгос	хэргийн тоо	963	1 054	1 207	1 007	1 179	1 054	1 123
	100 000 хүнд ногдох	9.0	10.0	11.7	9.9	11.9	10.8	11.8
Сингапур	хэргийн тоо	441	443	445	410	456	455	379
	100 000 хүнд ногдох	41.7	41.4	41.1	37.6	41.6	41.5	34.7
Энэтхэг	хэргийн тоо	4 721	5 045	5 446	5 368	5 484	7 112	8 541
	100 000 хүнд ногдох	1.1	1.2	1.3	1.2	1.3	1.6	2.0
Армен	хэргийн тоо	41	20	48	52	66	56	87
	100 000 хүнд ногдох	5.0	2.5	6.1	6.8	8.8	7.5	12.7

Эх үүсвэр: <https://www.unodc.org/>

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл 2013 онд Монгол улсад 2012 оноос 45 буюу 29.0 хувь, Казахстанд 245 буюу 2.1 дахин, Японд 159 буюу 3.7 хувь, Сингапурт 28 буюу 7.4 хувь, Армэнд 5 буюу 5.7 хувиар нэмэгдэж, харин Гонконгд 75 буюу 11.4 хувиар буурсан байна.

Зураг 5.1.1 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, сонгосон улсаар, 100 000 хүнд ногдохоор, 2007-2013 он



НҮБ-ын ГХМБТГ-ын тооцолсноор 100 000 хүнд ногдох хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл сонгосон улс орнуудаас Гонконг улсад сүүлийн жилүүдэд буурч байгаа ч хамгийн өндөр нь байна. Азийн сонгосон улс орнуудаас Монгол улс хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гаралт өндөртэй орнуудын тоонд багтаж байна.

6. ДҮГНЭЛТ

Улсын хэмжээгээр 2016 онд 27.2 мянган гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 590 (2.1%)-ээр буурсан байна.

Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 13.5 хувь нь Төвийн бүсэд, 10.7 хувь нь Хангайн бүсэд, 5.3 хувь нь Баруун бүсэд, 4.5 хувь нь Зүүн бүсэд, 65.9 хувь нь нийслэлд, 34.0 хувь нь аймгуудад, 0.1 хувь нь хилийн чанадад бүртгэгджээ.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.3 хувийг хүндэвтэр, 49.8 хувийг хөнгөн, 5.1 хувийг хүнд, 1.8 хувийг онц хүнд хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 2016 онд Дорноговь аймагт хамгийн бага (57.9), харин Баян-Өлгий (88.7), Сүхбаатар (84.0), Сэлэнгэ (79.8) аймгуудад хамгийн өндөр байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дүнгээр 64.0 хувь, нийслэлд 61.5 хувь болж, улсын хэмжээнд өмнөх оноос 1.9 пункт, нийслэлд 2.6 пунктээр тус тус өссөн байна.

Улсын дунджаар 18 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд 2016 онд 137 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оноос 4 хэрэг буюу 2.8 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл 2016 онд нийт гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 49.1 болж өмнөх оноос 0.7 пункт, Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 32.0 болж 1.5 пунктээр нэмэгдэж, харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 6.6 болж 0.6

пункт, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 5.4 болж 0.5 пункт, аж ахуйн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь 0.8 хувь болж, 1.1 пунктээр буурсан байна.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2016 онд 8691 бүртгэгдсэн нь өмнөх оноос 227 буюу 2.6 хувиар өсчээ. Хүнийг санаатай алах гэмт хэрэг өмнөх оноос 0.4 пункт, бусдыг болгоомжгүй алах хэрэг 0.1 пункт, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 0.3 пунктээр буурч, харин бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 0.7 пунктээр өсчээ.

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 60.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд Дархан-Уул(249), Хөвсгөл(235), Сэлэнгэ(233), Төв (233), Орхон (218), Дорноговь (223) аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн гаралт бусад аймгуудынхаас их байна.

Хүнийг санаатай алах хэрэг 2016 онд Сэлэнгэ, Хөвсгөл, Дорноговь, Дархан-Уул, Завхан, Архангай, Баян-Өлгий, Увс, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотод өмнөх оноос буурсан хэдий ч Булган, Орхон, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгуудад нэмэгдсэн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2016 онд 13336 бүртгэгдэж, өмнөх оноос 109 хэрэг буюу 0.8 хувиар буурахад энэ төрлийн гэмт хэргийн 68.0 хувийг эзэлж буй хулгайн хэрэг 104 (1.1%), үүний дотор мал хулгайлах гэмт хэрэг 375 (31.8%), халаасны хулгайн хэрэг 83 (13.4%), бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 63 (11.7%), бусдын эд хөрөнгийг булаах хэрэг 40 (18.5%), бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх хэрэг 11 (3.3%)- ээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2016 онд 1479 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 5.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 151 буюу 9.3 хувиар буурчээ.

Танхайн гэмт хэрэг 2016 онд 1449 бүртгэгдсэн нь өмнөх оноос 133 хэрэг буюу 8.4 хувиар буурахад Архангай, Булган, Ховд, Увс, Баянхонгор, Дундговь, Дархан-Уул аймгуудад энэ төрлийн гэмт хэргийн тоо өмнөх оноос 52.2-90.9 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам (ТХХАБАЖ)-ын эсрэг гэмт хэрэг 2016 онд 1783 болж, өмнөх оноос 227 хэрэг буюу 11.3 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 2016 онд 880 хүн нас барсны 399 буюу 45.3 хувь нь зам тээврийн ослын улмаас нас барсан нь өмнөх оноос 5.3 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас 2016 онд 11257 хүн гэмтсэний 1247 буюу 11.1 хувь нь зам тээврийн ослын улмаас гэмтжээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 399 хүний 89 буюу 22.3 хувь нь Улаанбаатар хотод гарсан хэргийн хохирогч байна.

Албан тушаалын гэмт хэрэг 2016 онд 111 бүртгэгдсэн нь өмнөх оноос 17 хэрэг буюу 13.3 хувиар буурсан байна. Сүүлийн 21 жилийн хугацаанд албан тушаалын гэмт хэргийн гаралт 2001 онд хамгийн олон (253) бүртгэгджээ.

2016 онд үйлдэгдсэн гэмт хэргийн 5520 буюу 20.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа нь өмнөх оноос 387 хэрэг буюу 6.6 хувиар буурав. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос буурахад Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Дорнод аймгуудад буурсан нь голлон нөлөөлжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2016 онд 1449 бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 буюу 6.9 хувиар нэмэгдсэн байна. 2016 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг нийт бүртгэгдсэн хэргийн 5.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өсөхөд Улаанбаатар(71) хотод, аймгуудаас Дорноговь(28), Баянхонгор (15), Баян-Өлгий(10)-аар өссөн нь голлон нөлөөлөв.

2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 75.3 хувь нь ажлын өдрүүдэд, 24.7 хувь нь амралтын өдрүүдэд үйлдэгджээ. Нийт гэмт хэргийн 15.8 хувь нь даваа гарагт үйлдэгдсэн бөгөөд үүний 66.9 хувь нь нийслэлд, 33.1 хувь нь аймгуудад байна. Сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр Даваа гарагт бусад гарагуудаас их хэрэг гардаг байна.

2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн зонхилох хэсэг нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн бөгөөд энэ дүр зураг нийслэл, аймагт ижил байна. Улсын хэмжээгээр бүртгэгдсэн гэмт хэргийн 21.7 хувь нь 06-14 цагт, 28.6 хувь нь 14-19 цагт, 15.1 хувь нь 19-22 цагт, 34.6 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.

2016 онд авто зам дээр гарсан гэмт хэргийн 52.0 хувь нь хотын замд, 41.9 хувь нь орон нутгийн замд гарсан ба замын хучилтаар авч үзвэл, 76.7 хувь нь асфальтан зам дээр, замын гадаргуугийн хувьд 60.8 хувь нь хуурай гадаргууд, замын онцлогоор харвал 64.9 хувь нь тэгш, 27.5 хувь нь шулуун замд үйлдэгджээ.

Хотын замд гарсан 875 хэргийн 841 буюу 96.1 хувь нь Улаанбаатар хотод гарсан ба дүүргүүдээс Сонгинохайрхан(208), Баянзүрх(180), Баянгол(131), Сүхбаатар(119)–т хамгийн их хэрэг бүртгэгджээ.

Хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, холбогчдын тоо 2016 онд 23.8 мянган хүн болж, өмнөх оноос 1052 хүн буюу 4.2 хувиар буурсан байна. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 53.9 хувь нь ажилгүй иргэд, 5.5 хувь нь оюутан, сурагчид, 40.6 хувь нь ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүс байна.

Гэмт хэргийн улмаас 2016 онд нийт 27.7 мянган иргэн, 84 байгууллага хохирсон нь 2015 оноос хохирогч иргэдийн тоо 259 хүнээр, хохирогч байгууллагын тоо 29-өөр буурчээ. 2016 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 13507 буюу 48.8 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг, 9126 буюу 33.0 хувь нь Хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг, 1995 буюу 7.2 хувийг ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон байна. Гэр бүлийн хүчирхийллээс хохирсон иргэдийн 57.3 хувийг эхнэр нь, 15.8 хувийг хамтран амьдрагч нь, 2.9 хувийг төрсөн хүүхэд нь, 2.1 хувийг дагавар хүүхэд нь эзэлж байна.

2016 оны байдлаар гэр бүлийн хүчирхийлэлд автсан иргэдийн 57.5 хувь нь Улаанбаатар хотын иргэд байна. Сэлэнгэ(50), Дархан-Уул(49), Орхон(47), Хөвсгөл(43), Төв(45) аймгууд болон Баянзүрх(234), Баянгол(127), Сонгинохайрхан(133) дүүргүүдийн иргэд гэр бүлийн хүчирхийлэлд хамгийн их автсан байна. Гэмт хэргийн улмаас 2016 онд 27689 иргэн хохирсны 880 буюу 3.2 хувь нь нас барж, 11257 буюу 40.7 хувь нь гэмтсэн байна. Хохирогч иргэдийн тоо өмнөх оноос 0.9 хувь, гэмтсэн иргэдийн тоо 0.3 хувиар буурч, харин нас барсан иргэдийн тоо 3.9 хувиар нэмэгдсэн.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 онд 162.9 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 44.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 18.6 (12.9 %) тэрбум төгрөгөөр өсч, харин нөхөн төлүүлсэн хохирол 5.0 (10.3 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улаанбаатар хотод гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 онд 117.2 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 24.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос учирсан хохирол 29.9 (34.2 %) тэрбум төгрөгөөр өсч, харин нөхөн төлүүлсэн хохирол 1.4 (5.5 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.

2016 онд 87.4 мянган хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оноос 10.2 мянга буюу 10.5 хувиар буурсан байна.

Анхан шатны шүүхээр 2016 онд 5762 эрүүгийн хэрэг, 46173 иргэний хэрэг, 1780 захиргааны хэрэг хянан шийдвэрлэгдэж, 7003 захиргааны зөрчилд хариуцлага ногдуулж, 945 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллаж, 3642 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ. Анхан шатны шүүхээр шийдвэрлүүлэхээр 2016 онд 7025 эрүүгийн хэрэг ирсэний 5762 буюу 82.0 хувь нь шийдвэрлэгдэж, 693 буюу 9.9 хувь нь мөрдөн байцаалтанд буцаж, 39 буюу 0.6 хувь нь хэрэг бүртгэлд буцаж, 22 буюу 0.3 хувь нь харьяаллын дагуу шилжсэнээр 511 буюу 7.3 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо 2016 онд 6566 болж, өмнөх оноос 1130 буюу 14.7 хувиар буурсан байна. Тухайн жилд сэжигтэн, яллагдагчаар татагдсан иргэдийн 27.6 хувь нь ял шийтгүүлсэн бөгөөд өмнөх оноос 3.4 пунктээр буурсан байна.

Ял шийтгүүлэгчдийн 1773 буюу 27.0 хувь нь урьд нь ял шийтгүүлж байсан, 451 буюу 6.9 хувь нь давтан хэрэг үйлдсэн, 1382 буюу 21.0 хувь нь бүлэглэн үйлдсэн, 1729 буюу 26.3 хувь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Ял шийтгүүлэгчдийн 518 буюу 7.9 хувь нь эмэгтэйчүүд, 360 буюу 5.5 хувь нь хүүхдүүд байна.

Шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн 9 буюу 0.1 хувь нь улс төрийн албан тушаалтан, 37 буюу 0.6 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 81 буюу 1.2 хувь нь төрийн тусгай албан хаагч, 144 буюу 2.2 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 454 буюу 6.9 хувь нь оюутан, сурагчид, 4111 буюу 62.6 хувь нь ажил эрхлээгүй хүмүүс байна.

2016 оны байдлаар шүүхээр 5762 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдэж, 15.2 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Анхан шатны шүүх 2016 онд 64.0 мянган нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас 11.2 мянган нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, буцаах, харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч, 46.2 мянган иргэний хэргийг хянан шийдвэрлэжээ. Энэ нь өмнөх оноос 5.5 мянга буюу 13.5 хувиар өссөн байна. Иргэний хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн 86.0 хувийг эзэлж өмнөх оноос 2.8 пунктээр өссөн байна.

Иргэний хэрэг өмнөх оноос өсөхөд худалдах, худалдан авах арилжаатай холбоотой маргаан 1810 (32.1%)-аар, зээлийн гэрээний маргаан 1184(19.1%)-өөр, банк, зээлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан 554(30.7%)-өөр, ажлаас үндэслэлгүй халсан маргаан 303 (33.2%)-аар, цалин хөлсний маргаан 238 (57.3%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулиар 2016 онд 2220 хөдөлмөрийн маргаан шийдвэрлэгдсэний 1213 буюу 54.6 хувь нь ажлаас үндэслэлгүй халагдсан, 653 буюу 29.4 хувь нь цалин хөлсний маргаан, 59 буюу 2.7 хувь нь ажлаас буруу шилжүүлсэн маргаан бөгөөд өмнөх оноос ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 6.6 пунктээр буурч, харин цалин хөлсний маргаан 1.5 пункт, ажлаас буруу шилжүүлсэн маргаан 1.5 пунктээр өссөн байна.

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2016 онд 4674 хэрэг шийдвэрлэгдсэний 2980 (63.8%) нь гэрлэлт цуцалсан, 450 (9.6%) нь эцэг тогтоосон, 1006 (21.9%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 17 (0.4%) нь эцэг, эх байх эрх хассан, 47 (1.0%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 174 (3.7%) нь бусад хэрэг байна.

“Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өмнөх оноос 115 (3.0%)-аар өсөхөд хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хэрэг 181(21.9%)-ээр, бусад хэрэг 73 (59.6%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Шүүхийн шийдвэрийн дагуу 2016 онд эрүүгийн хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 10.6 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 6.2 хувийг, иргэний хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 137.2 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 15.1 хувийг, захиргааны хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 1.3 тэрбум төгрөг болж, төлвөл зохих хохирлын 75.0 хувийг, бусад хэргийн хохирлын нөхөн төлүүлэлт 543.2 сая төгрөг болж, төлвөл зохих хохирлын 0.4 хувийг тус тус нөхөн төлүүлсэн байна. 2015 онд улсын хэмжээгээр шүүхийн шийдвэрийн дагуу гүйцэтгэвэл зохих учирсан хохирлын 19.8 хувийг нөхөн төлүүлсэн бол 2016 онд 12.3 хувийг нөхөн төлүүлж, нийт гүйцэтгэсэн нөхөн төлүүлэлт өмнөх оноос 7.5 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт эрүүгийн хэргийн хувьд жил бүр бага байдаг ба энэ нь хэрэгт холбогдогчдын

төлбөрийн чадвар муу, нөгөөтэйгүүр ажилгүй иргэд гэмт хэрэгт их холбогдогдож байгаатай холбоотой гэж үзэж болох талтай.

7. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон НҮБ-ын Статистикийн комиссоос батлан гаргасан Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангиллыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтүүдийн олон улсад харьцуулагдах байдлыг хангах явдал чухал байна.
- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газрын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны үзүүлэлтүүд болон Тогтвортой хөгжлийн 16-р зорилтын холбогдох үзүүлэлтүүдийг гаргах боломжийг бүрдүүлж ажиллах явдал тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.
- Сүүлийн 5 жилийн мэдээллээс харахад жил тутам улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 56-65 орчим хувь нь Улаанбаатар хотод бүртгэгддэг байна. Энэ нь нэг талаас нийслэлд амьдарч байгаа хүний тоо харьцангуй бусад бүсүүдээс олон байгаатай холбоотой хэдий ч, жил бүр 18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо ч нийслэлд улсын дунджаас харьцангуй өндөр байна. Эндээс харахад хүн ам хэт их төвлөрсөн нийслэл хотод гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- Гэмт хэрэгт холбогдогчдын 59.4 хувь нь ажилгүй иргэд болон оюутан, сурагчид, шүүхээр ял шийтгүүлэгчдийн 62.6 хувь нь ажилгүй иргэд, 46.3 хувь нь 18-29 насны иргэд байгаагаас харахад ажлын байргүйн улмаас залуучууд гэмт хэрэгт холбогдох улмаар ял шийтгэл авах явдал их байна. Иймээс ажлын байрыг шинээр бий болгох, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах явдал зайлшгүй чухал байна.
- 2016 онд гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн 45.3 хувь нь ТХХАБАЖ-ын эсрэг гэмт хэргийн улмаас амь насаа алдсан нь нийгэмд асар их хор хохирлыг учруулж байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн тоо 2016 онд буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож буй нийт жолооч, явган зорчигчдын үүрэг хариуцлагыг эрс дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд жолоочийн ур чадвар, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, нийт иргэдэд замын хөдөлгөөнд зүй зохистой оролцох соёл, дадал эзэмшүүлэх, замын чанар, гэрэлтүүлэг, жолооны сургалтын чанарыг сайжруулах, орон нутаг, гэр хорооллын замыг стандартад нийцүүлэх ажлуудыг хийх шаардлагатай байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2016 онд 1449 бүртгэгдсэн нь өмнөх оноос 93 буюу 6.9 хувиар нэмэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2016 онд 1357 хүн хохирсон нь 2015 оноос 50 буюу 3.8 хувиар нэмэгдэв. Эдгээр хүмүүсийн 1231 буюу 90.7 хувь нь эмэгтэйчүүд, 69 буюу 5.1 хувь нь 18 хүртэлх насны хүүхдүүд байна. Хүчирхийлэлд өртсөн иргэдийн 598 буюу 44.1 хувь нь ажилгүй иргэд байна. Энэ төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр хийх ажлыг эрчимжүүлэх, гэр бүл, эцэг эх, төрөл төрөгсөд, ах, эгч, ойр дотны хүмүүсийн байнгын хүчирхийлэлд өртөж байгаа бага насны хүүхдүүдэд тавих анхаарал халамжийг эрс сайжруулах, бүх шатны хүүхэд хамгаалах байгууллага, сургууль, цэцэрлэг, эцэг эхчүүд, цагдаа, хууль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг хүүхдийг хүчирхийллээс хамгаалахад чиглүүлэх, сургалт, семинар зохион байгуулах, бодит ажлуудыг хийх, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх хуулийг хэрэгжүүлэхэд бүх шатандаа анхаарч ажиллах нь чухал байна.

- Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хамгаалах, учирсан хохирлыг барагдуулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчлэх байр, нийгмийн бусад тусламжийн үйлчилгээг сайжруулж, шинэ шатанд гаргах хэрэгцээ, шаардлага байсаар байна.
- Одоогоор Монгол Улсад гэмт хэргийн хохирогчийн зөвхөн эд материалын хохирлын тодорхой хэсгийг нөхөн төлүүлж байгаа бөгөөд цаашид бусад хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөр, төсөл боловсруулан ажиллах хэрэгтэй байна.
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах болон бусдын эд хөрөнгийг хулгайлах, хувийн өмчийг хулгайлах гэмт хэргийн гаралт ч нэмэгдсээр байгаад анхаарч ажиллууштай байна.

..... о О о